МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬ, МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨРЧЛИЙН СУДАЛГАА”

Судалгааны төрөл:	**Хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгаа**
Судалгааны код:	**БГСТ-25/009**
Хугацаа:	**2025.03.12-2025.04.11**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: М.Нармандах, Судлаач, Эрх зүйч, Магистр

Улаанбаатар хот
2025

ТОВЬЁОГ

Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгтийн жагсаалт	2-3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:УДИРТГАЛ	
1.1.Судалгааны товч танилцуулга	4
1.2.Судалгааны зорилго	4
1.3.Судалгааны хамрах хүрээ	4
1.4.Судалгааны арга зүй	5-6
1.5.Судалгааны үр дүнгийн товч танилцуулга	7-9
ХОЁРДУГААР БҮЛЭГ:СУДЛАГДАХУУН	
2.1.Хууль 1. Малчны тухай хууль	9-27
2.2.Хууль 2. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	27-35
2.3.Хууль 3. Хоршооны тухай хууль	35-43
ГУРАВДУГААР БҮЛЭГ: САНАЛ, ЗӨВЛӨМЖ	
3.1.Санал, зөвлөмж	43-45
Хавсралт: 1. Ашигласан материал 2. Судлагдсан хуулиудын давхардал, зөрчил, хийдлийн нэгдсэн мэдээлэл 3. Малчны тухай хуультай холбогдох хуулийн зохицуулалт 4. Малчны өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуультай холбогдох хуулийн зохицуулалт 5. Хоршооны тухай хуультай холбогдох хуулийн зохицуулалт 6. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дугаар тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”	46

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	**Давхардал, зөрчил, хийдлийн хяналтын жагсаалт**
Хүснэгт 2	**Судалгаанд хамарсан хуулийн давхардал, зөрчил, хийдлийн хураангүй**
Хүснэгт 3	**Малчны тухай хуулийн бүлэг, зүйл**
Хүснэгт 4	**Цахим хуудасны хайлтын илэрц**
Хүснэгт 5	**Давхардал 7.1.1 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 6	**Давхардал 7.1.2 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 7	**Давхардал 7.1.3 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 8	**Зөрчил 7.2.1 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 9	**Зөрчил 7.2.1 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 10	**Зөрчил 7.2.3 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 11	**Зөрчил 7.2.4 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 12	**Зөрчил 7.2.7 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 13	**Хийдэл 7.3.1 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 14	**Хийдэл 7.3.2 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 15	**Хийдэл 7.3.3 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 16	**Хийдэл 7.3.4 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 17	**Хийдэл 7.3.5 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 18	**Хийдэл 7.3.6 судалгаа (Малчны тухай хууль)**
Хүснэгт 19	**Дүгнэлт (Малчны тухай хууль)**
Хүснэгт 20	**Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн бүлэг, зүйл**
Хүснэгт 21	**Цахим хуудасны хайлтын илэрц**
Хүснэгт 22	**Давхардал 7.1.2 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль,)**
Хүснэгт 23	**Зөрчил 7.2.1 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**
Хүснэгт 24	**Зөрчил 7.2.7 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**

Хүснэгт 25	**Зөрчил 7.2.13 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**
Хүснэгт 26	**Хийдэл 7.3.1 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**
Хүснэгт 27	**Хийдэл 7.3.2 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**
Хүснэгт 28	**Хийдэл 7.3.3 (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**
Хүснэгт 29	**Дүгнэлт (Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хууль)**
Хүснэгт 30	**Хоршооны тухай хуулийн бүлэг, зүйл**
Хүснэгт 31	**Цахим хуудасны хайлтын илэрц**
Хүснэгт 32	**Зөрчил 7.1.2. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 33	**Хийдэл 7.2.3. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 34	**Зөрчил 7.2.4. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 35	**Зөрчил 7.2.5. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 36	**Зөрчил 7.2.7. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 37	**Хийдэл 7.3.2. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 38	**Хийдэл 7.3.6. (Хоршооны тухай хууль)**
Хүснэгт 39	**Дүгнэлт (Хоршооны тухай хууль)**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
УДИРТГАЛ

1.1. Судалгааны товч танилцуулга

Монгол Улсын Их Хурлын даргын захирамжаар үндэсний хэмжээнд өрнөж байгаа “Хүнсний хувьсгал[1]”, “Цагаан алт[2]” болон “Шинэ хоршоо[3]” хөдөлгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх, бодлого, арга зүй, удирдлагаар дэмжих, хяналт тавих, холбогдох арга хэмжээний болон хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мөн хөтөлбөр хоорондын уялдаа холбоог сайжруулах зэрэг асуудлыг судалж, танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хүрээнд Ажлын хэсгээс “Малчны тухай хууль” болон “Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийг боловсронгүй болгох, давхардал, хийдэл, зөрчлийг тодорхойлох ажлын даалгаврыг өгсөн.

1.2. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь судалгааны хамрах хүрээнд тусгасан хуулиудын уялдаа, холбоо, хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд эдгээр хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг судласны үндсэн дээр санал, зөвлөмж боловсруулахад оршино.

1.3. Судалгааны хамрах хүрээ

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, түүний ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэх зорилго бүхий “Малчны тухай хууль”, малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж, нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий “Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийг тус тус баталсан болно. Дээр дурдсанчлан Ажлын хэсгээс энэхүү хоёр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлахыг даалгасан.

Харин 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр хоршоог үүсгэн байгуулах, хоршооны гишүүнчлэл, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, хяналт, үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Хоршооны тухай хууль (Шинэчилсэн найруулга) батлагдан хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэхүү хууль нь малчны хөдөлмөр эрхлэлт, тэдгээрийн эдийн

[1] Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол
[2] Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоол
[3] Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол

засаг, нийгмийн байдлыг нэмэгдүүлэх, эрх зүйн байдлыг тодорхой болгох төсөөтэй зохицуулалттай тул энэхүү судалгаанд хамруулан судлах нь зүйтэй гэж үзэв.

Иймд энэхүү судалгаагаар “Малчны тухай хууль”, “Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль” болон “Хоршооны тухай хууль”-ийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан тодорхойлсон болно.

1.4. Судалгааны арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зарим арга хэмжээний тухай” 68 дугаар тогтоолоор “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган, "Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал"-ыг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайдад даалгасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-ыг баталсан.

Харин 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулиар захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас баталж, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлснээр хүчин төгөлдөр болохоор заасан.

Дээр дурдсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал” нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүргэгдэж, нийтлэгдсэн талаар мэдээлэл байхгүй байх бөгөөд Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох https://legalinfo.mn/mn байршуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл, энэхүү судалгааг хийж гүйцэтгэхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан аргачлалыг дагаж мөрдөх үүрэггүй байна. Гэвч, хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг нарийвчлан судлахтай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний акт 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн байдлаар https://legalinfo.mn/mn нэгдсэн системд байршаагүй байх тул Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан аргачлалыг ашиглан судалгааг гүйцэтгэх нь зүйтэй гэж үзлээ.

Иймд, уг аргачлалд заасны дагуу судалгааны хамрах хүрээнд заасан хуулиудын давхардал, зөрчил, хийдлийг шалган тогтооход дараах шалгуурыг ашиглав:

Хүснэгт 1

Давхардал	
7.1.1	Тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх
7.1.2	Тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх
7.1.3	Төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх
7.1.4	Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардалыг арилгахад чиглэгдсэн эсэх.
Зөрчил	
7.2.1.	Тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;
7.2.2	Хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх
7.2.3	Хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх
7.2.4	Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх
7.2.5	Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх
7.2.6	Тодорхой асуудлыг тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх;
7.2.7	Хуульд заасан эшлэл алдаатай эсэх
7.2.8	Тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх
7.2.9	Татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх
7.2.10	Тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх
7.2.11	Өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх

7.2.12	Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх
7.2.13	Тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх
Хийдэл	
7.3.1	Тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх
7.3.2	Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх
7.3.3	Тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;
7.3.4	Тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх
7.3.5	Төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх
7.3.6	Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх
7.3.7	Тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх
7.3.8	Хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх
7.3.9.	Хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх

1.5. Судалгааны үр дүнгийн товч танилцуулга

Малчны тухай хууль болон Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зохицуулалтууд агуулгын хувьд давхардсан. Малчны тухай хуулиар малчин нь байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр заасан бол Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоо нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх,

борлуулах үйл ажиллагаанд гишүүдийн зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхээр заасан.

Малчин өрхийн анхдагч холбооны гишүүн нь малчин өрх байх бөгөөд малчин өрхийн гишүүн нь малчин юм. Өөрөөр хэлбэл, Малчны тухай хуулиар малчин өрхийг бий болгож байгаа малчин байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын эрүүл мэндийг хамгаалах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зэрэг үүргийг хүлээсэн байхад Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоо нь эдгээр үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхээр давхардуулан зохицуулсан байна.

Малчин, малчдын хамтын санаачилга, хоршилд гэрээгээр бэлчээр ашиглуулахтай холбоотой зохицуулалт байхгүй. Малчны тухай хуулиар малчин нь байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах эрхтэй бөгөөд бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх үүрэгтэй байхаар заасан. Мөн тус хуулиар малчны хамтын санаачилга, хоршил нь хот айл, малчны холбоо, малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани хэлбэртэй байхаар заасан боловч малчин, малчны хамтын санаачилга, хоршилд бэлчээр гэрээгээр ашиглуулахтай холбоотой зохицуулалт Малчны тухай хууль болон дагалдан гарсан хуулиудад тусаагүй байна.

Мөн Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгаж, мөн тус хуулийн дагалдан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг тусгажээ.

Иймд, одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд малчин өрхийн холбоонд хамаарахгүй малчин болон Малчны тухай хуульд заасан малчны хамтын санаачилга, хоршил нь гэрээгээр бэлчээр ашиглахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс шалтгаалан малчин малчин өрхийн холбоонд нэгдэх замаар бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахаас аргагүй байдалд хүрэх, улмаар сайн дурын үндсэн дээр малчин өрхийн холбоонд элсэх суурь зарчим гажуудах эрсдэлтэй байна.

Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн нэр хуулийн үйлчлэх хүрээнд нийцээгүйгээс гадна уг хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгаагүй. *Хууль тогтоомжийн тухай хуулиар*[4] хуулийн төслийн гарчиг нь хуулийн агуулгыг товч, тодорхой илэрхийлсэн хуулийн нэртэй байхаар заасан. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт

[4] https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119

нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршихоор заасан бөгөөд малчин өрхийн холбоо нь малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байхаар заасан. Иймд хуулийг бүхэлд нь малчин өрхийн холбооны бүрэлдэхүүн хэсэг болох малчин өрхийн нэгдсэн холбооны нэрээр нэрлэсэн нь зөрчил үүсгэж байна.

Мөн түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулиар хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах шаардлагыг тавьдаг. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, сэргээх, гэрээний үүргээ сахин биелүүлэх зэрэг үүргээс гадна холбооны үйл ажиллагаа, түүний тайланд тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг оруулаагүй нь энэхүү хууль нь эрх зүйн талаасаа чадваргүй, зөвхөн тунхагийн шинжтэй баримт бичиг болох эрсдэлтэй юм.

Хоршооны тухай хуулийг зөрчсөн зөрчлийг Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагчид хамааруулсан нь уг хуулийн хэгрэгжилтийг хангуулахад эрсдэл үүсгэж байна. Хоршооны тухай хуулиар хоршооны үйл ажиллагааны чиглэлийг өргөн хүрээтэй буюу хоршоо нь хууль тогтоомжоор хориглоогүй, хоршооны дүрэмд заасан үйл ажиллагаа явуулахаар заасан. Жишээлбэл, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршоо нь Хоршооны тухай хууль, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль зөрчсөн үйлдлийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам шалган шийдвэрлэх нь хамгийн зохистой. Иймд Хоршооны тухай хуулийг зөрчсөн зөрчлийг тухайн хоршооны үйл ажиллагааны чиглэлээс хамаарч тухайн салбарын төрийн захиргааны байгууллага хянан шийдвэрлэх нь хуулийн хэрэгжилтийн хангуулахад чухал нөлөөтэй.

Давхардал, зөрчил, хийдлийн нэгтгэсэн үр дүнг доорх хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 2

	Хуулийн нэр	**Давхардал**	**Зөрчил**	**Хийдэл**
1.	Малчны тухай хууль	6	7	15
2..	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	5	2	6
3	Хоршооны тухай хууль	3	4	2

ХОЁРДУГААР БҮЛЭГ
СУДЛАГДАХУУН

2.1. Малчны тухай хууль

Малчны тухай хуулийн зорилт нь малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, түүний ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэхэд оршино.

Тус хууль нийт 6 бүлэг, 14 зүйлтэй. УИХ-аас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан.

Хүснэгт 3

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**	
1 дүгээр зүйл.	Хуулийн зорилт
2 дугаар зүйл.	Малчны хууль тогтоомж
3 дугаар зүйл.	Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
ХОЁРДУГААР БҮЛЭГ **МАЛЧДЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО**	
4 дүгээр зүйл.	Малчдын талаар төрөөс баримтлах бодлого
ГУРАВДУГААР БҮЛЭГ **МАЛЧНЫ ХӨГЖИЛ, ТҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ**	
5 дугаар зүйл.	Малчны эрх, үүрэг
6 дугаар зүйл.	Малчны мэдлэгийг дээшлүүлэх тогтолцоо, зарчим
7 дугаар зүйл.	Малчны хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр
8 дугаар зүйл.	Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ **МАЛЧНЫ БҮТЭЭМЖ**	
9 дүгээр зүйл.	Малчны бүтээмжийг дэмжих
ТАВДУГААР БҮЛЭГ **МАЛЧНЫ ХАМТЫН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ**	

10 дугаар зүйл.	Малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа
11 дүгээр зүйл.	Уур амьсгалын өөрчлөлт, эрсдэлийн нөлөөллийг бууруулах
12 дугаар зүйл.	Малчинд үзүүлэх санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ
13 дугаар зүйл.	Малчны хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамжийг сайжруулах
ЗУРГАДУГААР БҮЛЭГ **БУСАД ЗҮЙЛ**	
14 дүгээр зүйл.	Санхүүжилт
15 дугаар зүйл.	Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага
16 дугаар зүйл.	Шилжилтийн үеийн зохицуулалт

Холбогдох хууль тогтоомж:

www.legalinfo.mn цахим сангаас “малчин”, “малчид”, “малчин өрх”, “хоршоо” “мал” гэсэн үг, тэдгээрийн хувирлаар хуультай холбогдох дараах хууль тогтоомж, эрх зүйн акт байна. Үүнд:

Хүснэгт 4

Хууль тогтоомж	Тоо
Хууль	11
УИХ-н тогтоол	3
ЗГ-ын Тогтоол	56
УДШ-ийн тайлбар	0
Үндсэн хуулийн цэцийн шийдвэр	0
УИХ-аас томилогддог байгууллагын шийдвэр	14

1. Давхардал

7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;

Хүснэгт 5

№	Малчны тухай хууль	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
1.	3.1.3."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "малчин" гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;” гэж, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

		4.1.14-д "малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг;” гэж, Малын генетик нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11-д "малчин" гэж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.14-д заасныг;” гэж, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д "малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;” гэж;”
	Малчны тухай хууль	**Хөдөлмөрийн тухай хууль**
2.	3.1.4."туслах малчин" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасныг;	Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д "туслах малчин" гэж үндсэн малчны дэргэд амьдарч, түүний удирдлага, хяналтын доор мал маллах, мал аж ахуйтай холбоотой бусад ажил эрхэлж цалин хөлс авахаар харилцан тохиролцон ажиллаж байгаа хүнийг ойлгоно. Бусдын малыг бие даан хөлсөөр маллахтай холбогдсон харилцааг Иргэний хуулиар зохицуулна.
Дүгнэлт: Малчны тухай хуулийн зорилго нь малчны эрх зүйн байдлыг тодорхойлохоор тусгагдсан боловч уг хуулийн гол эзэн болох малчны тодорхойлолтыг бусад хуулиас эшлэж ашигласан нь хуулийн зорилготой бүрэн нийцэхгүйгээс гадна хууль хэрэглээний хувьд шаардлаггүй хүндрэлийг бий болгож байна. Үүний оронд, Малчны тухай хуульд “малчин”, “туслах малчин” тодорхойлолтыг тусган бусад хуульд уг хуулиас эшлэлийг авч тусгах нь зохистой байна. Энэ нь “Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх аргачлал”-ын 3.2-т заасны дагуу уялдаа холбоог сайжруулах ажлыг хийхдээ хууль тогтоомжийн бичвэр болон агуулгыг харьцуулах бөгөөд хууль тогтоомж давхардсан, зөрчилдсөн гэж үзвэл түүнийг хууль тогтоомжийн эрэмбэлэлийн аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд бусад хууль, эрх зүйн актыг нийцүүлэх замаар ажиллана гэж заасантай нийцнэ. Мөн хуулийн нэр томьёоны тодорхойлолтын хэсэгт уг хуулийн зорилгод заасан “малчин” гэх тодорхойлолтыг тусгахаас өмнө “мал аж ахуй”, мал” зэргийг тодорхойлсон нь хуулийн зохицуулалтын зорилго, эрэмбээс зөрсөн байна.		
	Малчны тухай хууль	**Малын генетик нөөцийн тухай хууль**
3.	3.1.1."мал" гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;	4.1.1."мал" гэж уламжлагдан маллаж ирсэн таван хошуу малыг; 1.1.Энэ хуулийн зорилт нь мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтан /цаашид "мал" гэх/ ...

Дүгнэлт: Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-т “мал” гэж тодорхойлсон боловч уг хуулийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтан /цаашид "мал" гэх ... гэж өөр байдлаар тодорхойлсон байх бөгөөд нэгэнт таван хошуу малыг мал гэж тодорхойлсон бол зорилт хэсэгт заасныг хасах шаардлагатай.

Түүнчлэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд 4.1.1."мал" гэж уламжлагдан маллаж ирсэн таван хошуу малыг; гэж ижил, давхцуулан тодорхойлсон байна.

Иймд Малчны тухай хуульд “мал”-ын тодорхойлолтыг оруулж, Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд Малчны тухай хуулиас эшлэх нь зохистой байна.

7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;

Хүснэгт 6

№	Малчны тухай хууль	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
4.	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** 1.1.Энэ хуулийн зорилт нь малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, түүний ажиллах, амьдрах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлж, байгалийн чадамжид нийцсэн, өрсөлдөх чадвартай мал аж ахуйг хөгжүүлэхэд оршино.	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилго, зорилт** 1.1.Энэ хуулийн зорилго нь малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж, нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. 1.2.Энэ хуулийн зорилт нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Дүгнэлт: Дээрх хуулийн зорилт, зорилгын заалтууд нь агуулгын хувьд давхардсан байна. Тухайлбал, Малчны тухай хуулийн зорилт нь 1) малчинд төвлөрсөн, түүний		

эрх зүйн байдлыг тодорхойлж, амьдралын чанарыг дээшлүүлэх, 2) мал аж ахуйг үр ашигтай, таатай эрхлэх нөхцөл бий болгох, 3) байгалийн чадамжид нийцсэн мал аж ахуйг хөгжүүлэх гэсэн 3 зорилтыг дэвшүүлсэн байна. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зорилго нь мөн адил 1) бэлчээрийн мал аж ахуйг уламжлалт соёлыг хамгаалах, бэлчээрийн зохист хэрэглээ 3) малчдын хамтын ажиллагааг төлөвшүүлэх замаар амьдралын чанарыг дээшлүүлэх, 3) мал аж ахуйн үр ашгийг сайжруулах харилцааг зохицуулах зорилготой. Дүгнэвэл, малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, малчид хоорондын хамтрал, мал аж ахуйгаа хамтран хөгжүүлэх, улмаар байгалийн нөөц, бэлчээрийн зохистой ашиглалт, уламжлалыг хадгалан хамгаалах, малчны амьдралын чанарыг сайжруулах нь 2 хуулийн үндсэн зорилго байна. Харин эдгээр хуулийн нарийвчилсан бусад зохицуулалт нь өөр өөр харилцааг зохицуулж байна. Иймд энэ 2 бие даасан хуулийг нэгтгэн Малчны тухай нэг цогц хууль болгох боломжтой бөгөөд хуулийн хэрэглээний хувьд илүү хялбар болох юм.		
5.	5.2.1.байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх; 5.2.3.малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах; 5.2.4.мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах;	10 дугаар зүйл.Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх 11 дүгээр зүйл.Малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах 12 дугаар зүйл.Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх
Дүгнэлт: Малчны тухай хуулиар малчин нь байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр заасан бол Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоо нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулах үйл ажиллагаанд гишүүдийн зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхээр заасан. Малчин өрхийн анхдагч холбооны гишүүн нь малчин өрх байх бөгөөд малчин өрхийн гишүүн нь малчин юм. Өөрөөр хэлбэл, Малчны тухай хуулиар малчин өрхийг бий болгож байгаа малчин байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын эрүүл мэндийг хамгаалах, малын гараглтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зэрэг үүргийг хүлээсэн байхад Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоо нь эдгээр үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхээр давхардуулан зохицуулсан байна. Иймд, Малчин		

өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд Малчны тухай хуульд заасан зохицуулалтыг давхардуулахгүйгээр, эшлэх замаар өөрчлөлт оруулж, давхардлыг арилгах шаардлагатай байна.

7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;

Хүснэгт 7

№	Малчны тухай хууль	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
6.	4.2.7.гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгох; 4.2.8.гамшигт болон аюулт үзэгдэлд нийт мал сүргийнх нь 50 хувиас доошгүй нь өртсөн малчин өрх, эсхүл хонин толгойд шилжүүлснээр 250 хүртэл малтай, эсхүл 16-40 хүртэлх насны малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулах;	27.1.Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед анхдагч холбоонд төрөөс дэмжлэг үзүүлж болно.
Дүгнэлт: Малчны тухай хуульд заасны дагуу гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас хохирсон малчинд төрөөс тусламж үзүүлэх бол Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар анхдагч холбоонд дэмжлэг үзүүлэхээр заасан. Харин анхдагч холбоонд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ, төрлийг нарийвчлан заагаагүй байна.		

2.Зөрчил

7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

Хүснэгт 8

№	Малчны тухай хууль	Зөрчил
1.	3.1.2."мал аж ахуй" гэж уур амьсгалын нөхцөлд дасан зохицсон, байгалийн нөөц, чадавхад нийцсэн, уламжлалт	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар

	болон шинжлэх ухааны арга барилд суурилсан био үйлдвэрлэлийг;	баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-д зааснаар хэрэглэж хэвшсэн нэр томьёонд тайлбар хийхгүй бөгөөд нэр томьёоны тайлбарыг зөвхөн дараах тохиолдолд хийдэг. - нэр томьёо нь олон утгатай бөгөөд хуулийг нэг утгаар ойлгох боломжгүй байдал үүсэх; - нэр томьёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай; - шинээр бий болсон ойлголт буюу тухайн нэр томьёо нийтэд ойлгомжгүй; - нэр томьёоны мэргэжлийн утга нь өдөр тутам хэрэглэдэг ижил үгээс өөр, эсхүл нэр томьёог тогтсон утгаас нь өөр утгаар хэрэглэх.
2.	3.1.6."хот айл" гэж хоёр ба түүнээс дээш малчин өрх хамтран хөдөлмөрөө хоршин мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрийг;	

Дүгнэлт: Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.4-т заасан нэр томъёоны тайлбар хийх шаардлагыг дээрх тодорхойлолт хангахгүй гэж үзэж байна. Тухайлбал, 30.4.1.нэр томьёо нь олон утгатай бол; 30.4.2.нэр томьёо нь өргөн утгатай бөгөөд түүнийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай бол; 30.4.3.шинээр бий болсон ойлголт буюу нэр томьёо нь нийтэд ойлгомжгүй бол гэж заасны алинд нь хамаарч байгаа нь тодорхойгүй.

Мөн тодорхойлолтоос үзэхэд аливаа мал аж ахуй нь нэгдүгээрт уур амьсгалын нөхцөлд дасан зохицсон байх, байгалийн нөөц, чадавхид нийцсэн байх, уламжлалт болон шинжлэх ухааны арга барилаар явагдах үйлдвэрлэл байх зэрэг аливаа шаардлага хангасан үйл ажиллагааг байхаар тодорхойлсон нь оновчгүй. Мал аж ахуй гэдэг нь хэвшсэн ойлголт мөнөөс гадна мал, амьтныг гэршүүлэн тэжээж, малын үр шимийг нь хүртэж байгаа үйл ажиллагаа бөгөөд энэ тодорхойлолтод заасан олон шаардлагыг тоочих нь оновчгүй бөгөөд ач холбогдолгүй байна.

Түүнчлэн “хот айл” гэж уламжлалт, хэвшсэн ойлголтыг хуульчлан тодорхойлсон байх ба уг хуульд “хот айл” нь үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, зөвшилцсөн дүрэмтэй байх шаардлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, уламжлалт байдлаараа, сайн дураар хамтран мал аж ахуй эрхлэн оршин тогтнож байсан малчин өрхийн хоршин амьдарч байгаа нэгдэл дундаа баримтлах дүрэмгүй бол хот айл гэж хуулийн хувьд тооцогдохгүй. Мөн Иргэний хуульд заасан

бүртгэгдээгүй холбооны байдлаар эрх зүйн харилцаанд оролцох буюу 481.1-т заасны дагуу “Хамтран ажиллах гэрээ” байгуулахаар болсон байна.

Энэ нь хот айл, малчны холбоо зэрэг бүртгэгдээгүй холбоонд үүсэх асуудлыг шийдвэрлэхэд баримтлах тодорхой зохицуулалттай болгож байгаа хэдий ч хамтран зөвшилцсөн дүрэм, бас хамтран ажиллах гэрээ зэргийг хот айлын малчин өрхүүд байгуулах нь эргэлзээтэй.

Хүснэгт 9

№	Малчны тухай хууль
3.	7.3.Газрын тухай хуулийн 52.7-д зааснаас өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно.
Дүгнэлт: Газрын тухай хуулийн 52.7-д “Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно.” гэж заасан. Малчны тухай хуулийн 10.4.6-д зааснаар малчин, хот айл, малчдын холбооны санал, санаачилгаар цас бороoны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах тохиолдолд эдгээр байгууламжийг хот айл дундын эзэмшлийн буюу өвөлжөө, хаваржааныхаа газар болон ойролцоо байгуулах шаардлагатай тул 7.3-т заасан хориглох заалтыг боловсронгуй болгож хязгаарыг тодорхойлох шаардлагатай.	

7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;

Хүснэгт 10

№	Малчны тухай хууль
4.	7.3.Газрын тухай хуулийн 52.7-д зааснаас өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно. 7.4.Залуу малчин гэр бүлд болон хот, сууринаас шилжин очиж, 2-оос доошгүй жил тасралтгүй мал маллаж байгаа малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газрыг эзэмшүүлэх, бэлчээр ашиглуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрт үндэслэн сум, дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ
Дүгнэлт: Хуулийн 7 дугаар зүйл нь Малчны хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөрийг зохицуулж байгаа бөгөөд зүйлийн агуулгатай нийцэхгүй байна. **Мөн зөвшөөрөл олгохыг хэнд хориглож байгаа нь тодорхойгүй.**	

5.	ТАВДУГААР БҮЛЭГ МАЛЧНЫ ХАМТЫН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ
Дүгнэлт: Хуулийн тавдугаар бүлэг нь малчны хамтын санаачилгыг дэмжих нэртэй боловч мөн хуулийн 10.1 дэх хэсэгт малчны хамтын санаачилга, хоршлын хэлбэрийг, 10.4 дэх хэсэгт “Төрөөс малчны хамтын санаачилга, хоршлыг дэмжих” байдлыг заасан. Өөрөөр хэлбэл, тус бүлэг нь малчны хамтын санаачилга, хоршлыг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулж байх тул бүлгийн нэр агуулгатай нийцэхгүй байна.	
6.	10 дугаар зүйл.Малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа
Дүгнэлт: Гадаад нэр томъёог хэрэглэсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн 30.5-д зааснаар 1) уг нэр томьёог оноосон нэр монгол хэлэнд байхгүй бол; 2) уг нэр томьёог олон улсын хэмжээнд нийтлэг хэрэглэж хэвшсэн бол; 3) уг нэр томьёог Монгол Улсын олон улсын гэрээнд хэрэглэж байгаа бол гадаад нэр томъёо хэрэглэнэ. Мөн уг зүйлийн 30.7-д “Нэр томьёо нь тодорхой утга агуулгаар зөвхөн нэг бүлэг, зүйл, хэсэг, заалтын хүрээнд хэрэглэгдэх бол түүний тодорхойлолт, тайлбарыг холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтын дотор байрлуулж болно.” гэж заасан. Өөрөөр хэлбэл “кластер” гэсэн үгийг хуульд зөвхөн нэг газар, нэг удаа ашигласан байгаа ба монгол хэлэнд кластер гэсэн үгийг орчуулаагүй хэрэглэжээ. **“**Кластер” буюу кластерийн үйл ажиллагаа (cluster) гэдэг нь гэж газар зүйн байршлын хувьд болон нэмүү өртөг бий болгох боломжтой зорилго, үйл ажиллагаагаар хорших, төрөлжих хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллахыг ойлгоно. Малчны тухай хуульд “кластер” гэсэн үгийг ашиглахдаа шууд галиглан ашигласан байх бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тодорхой тохиолдолд энэ нь зөвшөөрөгдөнө. **Харин энэ хуульд “кластер”-г өөр байдлаар дахин ашиглаагүй байх хасах буюу монгол үгээр орчуулан илэрхийлэх нь зүйтэй байна.**	

7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгагүй, ойлгомжтой байгаа эсэх;

Хүснэгт 11

№	Малчны тухай хууль	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
7.	10.1.2.малчдын холбоо; 10.2.Энэ хуулийн 10.1.1,10.1.2-т заасан малчны хамтын хоршлын хэлбэр нь Иргэний хуулийн 481.1, 481.2-т заасны дагуу сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж, үйл ажиллагааны чиглэл, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, зөвшилцсөн,	5.1.Малчин өрхийн холбоо нь гишүүддээ үйлчилдэг, ашгийн төлөө бус хуулийн этгээд байна. Малчин өрхийн холбоо нь малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байна.

	тэдгээрийг дүрмээр баталгаажуулсан байна. 10.3.Энэ хуулийн 10.1.3-т заасан хамтын хоршлын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.	
Дүгнэлт: Малчны тухай хуулиар малчны хамтын санаачилга, хоршил нь 1. Хот айл, 2. Малчдын холбоо, 3. малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани байхаар заасан боловч Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон “малчин өрхийн холбоо”-г уг төрөлд оруулаагүй байна. Малчны тухай хуульд заасан малчдын холбоо нь Иргэний хуулийн дагуу “бүртгэгдээгүй холбоо” хэлбэртэй байх ба Малчин өрхийн холбоо нь уг хуулиар малчдын санаачилга, хоршилд хамаарахгүй байдлаар тусгажээ.		

7.2.7.хуульд заасан эшлэл алдаатай эсэх;

Хүснэгт 12

№	Малчны тухай хуулийн эшлэл бүхий зохицуулалт	Эшлэл, эшлэлийн дугаар алдаатай эсэх
1.	3.1.1."мал" гэж Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.1-д заасныг;	Үгүй
2.	3.1.3."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;	Үгүй Гэхдээ энэ эшлэлийн талаар 7.1.1-д заасан давхардлын хэсэгт тусад нь дүгнэсэн.
3.	3.1.4."туслах малчин" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасныг;	Үгүй Дээрхтэй ижил.
4.	3.1.5."малчин өрх" гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасныг;	Үгүй
5.	4.2.Засгийн газар энэ хуулийн 4.1-д заасан бодлогыг хэрэгжүүлэхээс гадна дараах арга хэмжээг авна:	Үгүй
6.	4.3.Энэ хуулийн 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.	Үгүй
7.	5.3.Энэ хуулийн 5.2.1-д заасан үүргийг биелүүлэх хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:	Үгүй
8.	5.3.3.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалах, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан хадлан, гар тэжээл бэлтгэх.	Үгүй

9.	5.4.Энэ хуулийн 5.2.2-т заасан үүргийг биелүүлэх хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:	Үгүй
10.	5.5.Энэ хуулийн 5.2.3-т заасан үүргийг биелүүлэх хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:	Үгүй
11.	5.6.Энэ хуулийн 5.2.4-т заасан үүргийг биелүүлэх хүрээнд дараах зохистой дадлыг хэрэгжүүлнэ:	Үгүй
12.	6.2.Энэ хуулийн 6.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.	Үгүй
13.	6.3.Энэ хуулийн 6.2-т заасан хөтөлбөр нь сургалтын нэгдсэн стандарт, бүс нутгийн онцлогт нийцсэн байна.	Үгүй
14.	6.4.Энэ хуулийн 6.2-т заасан байгууллага сургалтын нэгдсэн стандарт, хөтөлбөрийг багцлан боловсруулах бөгөөд хөтөлбөрт доор дурдсан чиглэлийн мэдлэг, ур чадварыг олгох асуудлыг тусгана:	Үгүй
15.	7.3.Газрын тухай хуулийн 52.7-д зааснаас өөр чиглэлээр давхцуулан газар ашиглах, эзэмшүүлэх, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хориглоно.	Үгүй
16.	7.6.Энэ хуулийн 7.2-т заасан төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тухайн шатны төсвийн захирагч жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.	Үгүй
17.	7.7.Энэ хуулийн 7.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг малын тоо толгойн албан татвараас төвлөрөх орлогын эх үүсвэрээс бүрдүүлэх асуудлыг холбогдох журамд заасны дагуу хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.	Үгүй
18.	9.6.Халдварт өвчингүй, эрүүл мал сүрэгтэй малчин өрхийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу баталгаажуулна.	Үгүй
19.	9.10.Улсын аварга, хошой аварга малчин, саальчин, фермер шалгаруулах болон энэ хуулийн 9.4-т заасан малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд урамшуулал олгох журмыг Засгийн газар батална.	Үгүй
20.	10.2.Энэ хуулийн 10.1.1,10.1.2-т заасан малчны хамтын хоршлын хэлбэр нь Иргэний хуулийн 481.1, 481.2-т заасны дагуу сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдаж, үйл ажиллагааны	Үгүй

	чиглэл, хамтран ажиллах хэлбэрээ харилцан тохиролцож, зөвшилцсөн, тэдгээрийг дүрмээр баталгаажуулсан байна.	
21.	10.3.Энэ хуулийн 10.1.3-т заасан хамтын хоршлын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.	Үгүй
22.	12.3.Энэ хуулийн 12.2-т заасан зээлийг арилжааны банкны болон доор дурдсан шаардлагыг хангасан малчинд олгоно.	Үгүй
23.	12.7.Энэ хуулийн 12.2-т заасан зээлийн хүүгийн хөнгөлөлтөд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгана.	Үгүй
24.	13.2.Энэ хуулийн 13.1-д заасан сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:	Үгүй
25.	13.2.4.энэ хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3-т заасан этгээдийн хувь нийлүүлэх хөрөнгө;	Үгүй
26.	13.3.Энэ хуулийн 13.1-д заасан сангийн хөрөнгийн 30 хувийг бэлчээрийн мал ахуйд гамшиг, эрсдэлийн үед ашиглахаар хуримтлуулна.	Үгүй
27.	13.5.Энэ хуулийн 13.4.1, 13.4.2-т заасан зориулалтаар зарцуулах хөрөнгө нь бага хүүтэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл хэлбэртэй байна.	Үгүй
28.	13.8.Энэ хуулийн 13.7-д заасан тогтолцоог төр, хувийн хэвшил, малчны өөрөө удирдах байгууллагын хамтын гэрээ, үйл ажиллагаагаар хөгжүүлнэ.	Үгүй
29.	15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Үгүй
30.	15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Үгүй
Дүгнэлт: Малчны тухай хуульд алдаатай эшлэл байхгүй байна.		

3.Хийдэл

7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;

Хүснэгт 13

№	Малчны тухай хууль
1.	10.3.Энэ хуулийн 10.1.3-т заасан хамтын хоршлын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.
Дүгнэлт: Энэ хуулийн 10.1.3-т малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани гэж заасан бөгөөд Нөхөрлөлийн тухай хууль (1995), Хоршооны тухай хууль (2021), Компанийн тухай хууль (2011) тус тус батлагдсан. Үүнээс гадна хамтын хоршилд хамаарах нэг хэлбэр нь Малчин өрхийн холбоо бөгөөд энэ нь Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулагдана.	

7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;

Хүснэгт 14

№	Журам батлах эрх олгсон зохицуулалт	Батлагдсан эсэх
	4.3.Энэ хуулийн 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна.	Энэ хэсэгт заасан заалт тус бүрээр судлав.
2.	4.2.4.малчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор орон сууцны ипотекийн зээлийн хөтөлбөрт хамруулах, зээлийн хөнгөлөлт үзүүлэх;	Батлагдаагүй.
3.	4.2.5.малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах;	Батлагдаагүй.
4.	4.2.6.эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах хүсэлт гаргасан малчныг холбогдох хууль	Батлагдаагүй.

	тогтоомжийн дагуу жил бүр үнэ төлбөргүй хамруулах;	
5.	4.2.7.гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас малчин ажил үүргээ гүйцэтгэж яваад амь насаа алдсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 48 сараар тооцож, түүнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь Засгийн газрын нөөц сангаас олгох;	Батлагдаагүй.
6.	4.2.8.гамшигт болон аюулт үзэгдэлд нийт мал сүргийнх нь 50 хувиас доошгүй нь өртсөн малчин өрх, эсхүл хонин толгойд шилжүүлснээр 250 хүртэл малтай, эсхүл 16-40 хүртэлх насны малчин өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулах;	Батлагдаагүй.
7.	4.2.9.хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх; 16.1.Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.	Батлагдаагүй. Уг хуульд зааснаар ЗГ-аас холбогдох журмыг батлах шаардлагатай бөгөөд тайланг боловсруулах хугацаанд уг журмыг батлаж гаргаагүй байна. Журмын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын цахим хуудсад байршуулсан байна. https://mlsp.gov.mn/content/detail/3628
8.	6.2.Энэ хуулийн 6.1-д заасан сургалтын хөтөлбөрийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, сургалтыг их сургууль, коллеж, мэргэжил, сургалт үйлдвэрийн төв, иргэний нийгмийн байгууллагын оролцоотойгоор үндэсний хэмжээнд зохион байгуулна.	Батлагдаагүй.
9.	7.2.Аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны	Нэгдсэн мэдээлэл байхгүй.

	хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавина.	
10.	7.8.Малчны хөгжлийн төвийн ажиллах журмыг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.	Нэгдсэн мэдээлэл байхгүй.
Дүгнэлт: Малчны тухай хууль нь 2024 оны 6 сард батлагдсан бөгөөд харьцангуй шинэ хууль тул уг хуулийн нарийвчилсан зохицуулалтын журам батлагдаагүй байна. Харин шилжилтийн үеийн зохицуулалтын дагуу 2026 оны 1 дүгээр сар хүртэл үйлчлэх 4.2.9-д заасан журмыг яаралтай батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна.		

7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;

Хүснэгт 15

№	Малчны тухай хууль
11.	7.7.Энэ хуулийн 7.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг малын тоо толгойн албан татвараас төвлөрөх орлогын эх үүсвэрээс бүрдүүлэх асуудлыг холбогдох журамд заасны дагуу хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.
Дүгнэлт: Хуулийн 7.2-т аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг Малын тоо толгойн татвараас төвлөрөх эх үүсвэрээс бүрдүүлэх агуулгатай заалт боловч тодорхой ямар журмаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх тодорхой бус. Төсвийн тухай хуулийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулахаар заасан бөгөөд нарийвчилсан журам тодорхойгүй.	

7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх;

Хүснэгт 16

№	Малчны тухай хууль
12.	5.1.Малчин дараах эрхийг эдэлнэ:

	5.1.2.байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах; 5.2.Малчин дараах үүргийг хүлээнэ: 5.3.2.бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх;
Дүгнэлт: Малчны тухай хуулиар малчин нь байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах эрхтэй бөгөөд бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх үүрэгтэй байхаар заасан. Мөн тус хуулиар малчны хамтын санаачилга, хоршил нь хот айл, малчны холбоо, малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани хэлбэртэй байхаар заасан боловч малчин, малчны хамтын санаачилга, хоршилд бэлчээр гэрээгээр ашиглуулахтай холбоотой зохицуулалт Малчны тухай хууль болон дагалдан гарсан хуулиудад тусаагүй байна. Мөн Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгаж, мөн тус хуулийн дагалдан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг тусгажээ. **Иймд, одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд малчин өрхийн холбоонд хамаарахгүй малчин болон Малчны тухай хуульд заасан малчны хамтын санаачилга, хоршил нь гэрээгээр бэлчээр ашиглахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс шалтгаалан малчин малчин өрхийн холбоонд нэгдэх замаар бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахаас аргагүй байдалд хүрэх, улмаар сайн дурын үндсэн дээр малчин өрхийн холбоонд элсэх суурь зарчим гажуудах эрсдэлтэй байна.**	
13.	8.1.Малчны үйл ажиллагаанд дараах цахим шилжилтийг нэвтрүүлнэ:
Дүгнэлт: Энэ хуулийн 8 дугаар зүйлд Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх талаар дараах зүйлсийг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх субьект тодорхойгүй. Үүнд: 8.1.1.хөдөлгөөнт холбоо, телевиз, интернэт сүлжээний үйлчилгээ; 8.1.2.мэдээлэл авах, солилцох нэг цонхны цахим үйлчилгээ; 8.1.3.банк, санхүү, татвар, худалдааны цахим үйлчилгээ; 8.1.4.төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний цахим систем; 8.1.5.малын бүртгэлийн систем; 8.1.6.гойд ашиг шимт, шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа, захиалга, малын тэжээл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цахим	

худалдаа; 8.1.8.технологийн сүлжээгээр дамжуулан малчдад мэдлэг түгээх бусад цахим үйлчилгээ зэрэг болно. Уг зүйлийн 8.1.7-д заасан газрын бүртгэл, кадастрын зураглал, бэлчээрийн төлөв байдал, чанарын үнэлгээний үйлчилгээний харилцаа нь Газрын тухай хууль болон бусад хуулиар зохицуулагдаж байгаа. Улмаар зөрчил гарсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар ямар этгээдэд зөрчлийн хэрэг үүсгэх нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.

7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;

Хүснэгт 17

№	Малчны тухай хууль
14.	**16.1.Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.**
Дүгнэлт: Уг хуульд зааснаар ЗГ-аас холбогдох журмыг уг заалтын хүчинтэй хугацаанд бүрэн хэрэгжиж дуусах боломжтой хугацаанд батлах шаардлагатай бөгөөд энэхүү тайланг боловсруулах үед уг журмыг батлаж гаргаагүй байна. Журмын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын цахим хуудсанд[5] байршуулсан байна.	

7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;

Хүснэгт 18

№	Малчны тухай хууль
15.	**15.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.** **15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.**
Дүгнэлт: Төрийн албаны тухай хуульд албан тушаалтанд хүлээлгэх арга хэмжээг тодорхой тусгасан. Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 48.1-т “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 37, 39 дүгээр зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн үйлчилгээний албан хаагчаас бусад албан хаагчид дараах сахилгын шийтгэлийн аль тохирохыг ногдуулна:” гэж заасны дагуу холбогдох арга хэмжээг авах боломжтой. Харин Зөрчлийн тухай хуульд уг хууль батлагдсантай холбоотой дараах зүйлийг нэмсэн боловч Малчны тухай хуулиар тогтоосон журам зөрчих гэсэн зөрчил нь өөрөө тодорхойгүй байна. **“13.11 дүгээр зүйл.Малчны тухай хууль зөрчих**	

[5] https://mlsp.gov.mn/content/detail/3628

1.Малчны тухай хуулиар тогтоосон журмыг зөрчсөн хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Малчны тухай хуульд тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглосон заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай. Тухайлбал, Малчны тухай хуулийн “11.5.Бэлчээрийг хаших, хөрсийг эвдэх болон мэргэжлийн байгууллагаас доройтлыг нь тогтоосон бэлчээрээс ургамал түүх, хадлан хадахыг хориглоно” гэж заасан заалтыг дурдаж болно.
Харин Зөрчлийн тухай хуульд заасан бусад хуулийн зөрчлийн хэрэгтэй давхцуулахгүй байдлаар тусгах шаардлагатай. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлд Байгалийн ургамлын тухай хууль зөрчих зөрчил зүйлийн 2-т “Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан зөрчилтэй давхцуулахгүйгээр зөрчлийн шинж, зөрчлийн хэргийг харъяалан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг хуульд тодорхой тусгах хэрэгтэй.

2.1.1. Дүгнэлт

Малчны тухай хуулийг шалгуур үзүүлэлтээр авч үзвэл давхардал, зөрчил, хийдэл бүхий нийт 28 зохицуулалт байгаагаас:

Хүснэгт 19

Шалгуур үзүүлэлт	Тоо
Давхардал	
7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх	3
7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх	2
7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх	1
Нийт давхардал	***6***
Зөрчил	
7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	3

7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх	3
7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгагүй, ойлгомжтой байгаа эсэх	1
Нийт зөрчил	***7***
Хийдэл	
7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх	1
7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх	9
7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох	1
7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх	2
7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх	1
7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	1
Нийт хийдэл	***15***

2024 онд батлагдсан Малчны тухай хууль нь Монгол Улсын малчдын эрх зүйн байдлыг анх удаа тусгайлан зохицуулсан, шинэлэг, стратегийн ач холбогдол бүхий хууль юм. Уг хууль нь төрөөс малчдын талаар баримтлах бодлогын үргэлжлэл төдийгүй малчдын нийгэм, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, тогтвортой амьжиргааг бий болгоход чиглэж байна.

Хуулийн онцлог нь:

- Малчны эрх зүйн байдлыг анх удаа тодорхойлж, хуульчлан баталгаажуулсан;
- Малчин болон түүний өрхийн эдийн засгийн чадавх, нийгмийн хамгааллыг бэхжүүлэх үндэс суурийг тавьсан;
- Төр, малчин, хувийн хэвшлийн уялдаа холбоог хуулийн хүрээнд зохицуулж, хамтын ажиллагааны ил тод, хариуцлагатай механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн.

Тус хуулийн давхардал бүхий зохицуулалтуудаас шалгуур үзүүлэлтийн “тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх” хэсэгт хамаарах давхардал хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд давхардал бүхий хууль нь "Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай" хууль байна.

Иймд, цаашид Малчны тухай хуульд заасан зорилго, зарчмыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд "Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай" хууль болон холбогдох бусад хууль, бодлогын баримт бичгүүдтэй зорилго, агуулгын хувьд уялдуулах шаардлагатай байна. Энэ хүрээнд дээрх хоёр хуулийг нэгтгэж, малчдын эрх зүйн орчныг илүү цогц, үр ашигтай болгон хөгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Мөн хуулийн зөрчил бүхий зохицуулалтуудаас “тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх” болон “хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх” шалгуур үзүүлэлтэд хамаарах зөрчил давамгайлж байна. Малчны тухай хуулийн нэр томьёо болон зарим зохицуулалтын агуулга нь хууль зүйн үндэслэл, логик дараалалтай зөрчилдөж байсан бөгөөд, тодруулбал “Мал аж ахуй” болон “Хот айл” гэх нэр томьёог хуульд тайлбарласан нь "Хууль тогтоомжийн тухай хууль”-ийн 30.4 дэх хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангаагүй, “Хот айл”-тай холбогдох эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангагдах эсэх эргэлзээтэй мөн тавдугаар бүлгийн нэр агуулгатай нийцээгүй.

Иймд, дээр дурдсанчлан, Малчны тухай хуулийн зарим нэр томьёог хуулийн зорилттой нийцүүлэх, бүлгийн нэрийг тухайн бүлэгт заасан зохицуулалттай нийцүүлэх тус тус шаардлагатай байна.

Харин хуулийн хийдэл бүхий зохицуулалтуудаас “тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх” шалгуур үзүүлэлт хамаарах хийдэл дийлэнх олонхи хувийг эзэлсэн. Хуульд тусгасан бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг боловсруулах эрхийг төрийн байгууллагад шилжүүлсэн боловч эдгээр журам, аргачлал хараахан батлагдаагүй байна. Иймд Засгийн газар холбогдох журмуудыг нэн даруй батлан хэрэгжүүлэх нь чухал байна.

Мөн түүнчлэн Малчны тухай хууль, түүнийг дагалдан гарсан хуулиудад малчин, малчдын хамтын санаачилга, хоршилд гэрээгээр бэлчээр ашиглуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаагүй нь малчин өрхийн холбоонд хамаарахгүй малчин болон малчны хамтын санаачилга, хоршил нь малчин өрхийн холбоонд нэгдэх замаар бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахаас аргагүй байдалд хүрэх, улмаар сайн дурын үндсэн дээр малчин өрхийн холбоонд элсэх суурь зарчим гажуудах эрсдэлийг бий болгож байна. Энэхүү эрсдэлийг бууруулах хүрээнд Малчны тухай хуульд малчин, малчны хамтын санаачилга, хоршлын

гэрээгээр бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг нэмэлтээр тусгах нь зүйтэй байна.

2.2. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль

Энэхүү хуулийн зорилго нь малчин, мал, бэлчээрийн харилцан шүтэлцээнд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт соёлыг хадгалах, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж, нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад нь тохируулан зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах замаар малчдын амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Мөн хуулийн зорилт нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нийт 5 бүлэг, 27 зүйлтэй. УИХ-аас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр баталсан.

Хүснэгт 20

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**	
1 дүгээр зүйл.	Хуулийн зорилго, зорилт
2 дугаар зүйл.	Малчин өрхийн нэгдсэн холбооны хууль тогтоомж
3 дугаар зүйл.	Хуулийн үйлчлэх хүрээ
4 дүгээр зүйл	Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
5 дугаар зүйл	Малчин өрхийн холбооны эрх зүйн байдал, үйл ажиллагаанд баримтлах зарчим
6 дугаар зүйл	Малчин өрхийн холбооны дүрэм
ХОЁРДУГААР БҮЛЭГ **МАЛЧИН ӨРХИЙН АНХДАГЧ ХОЛБОО, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**	
7 дугаар зүйл.	Малчин өрхийн анхдагч холбоог үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх
8 дугааар зүйл.	Анхдагч холбоо, түүний үйл ажиллагаа
9 дүгээр зүйл.	Боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах
10 дугаар зүйл.	Гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх

11 дүгээр зүйл.	Малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах
12 дугаар зүйл.	Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх
ГУРАВДУГААР БҮЛЭГ АНХДАГЧ ХОЛБООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ	
13 дугаар зүйл.	Анхдагч холбооны удирдлага, зохион байгуулалт
14 дүгээр зүйл.	Бүх гишүүдийн хурлын бүрэн эрх
15 дугаар зүйл.	Анхдагч холбооны гишүүнчлэл дуусгавар болох
16 дугаар зүйл.	Бүх гишүүдийн хурал
17 дугаар зүйл.	Ахлагч, түүний эрх үүрэг
18 дугаар зүйл.	Анхдагч холбооны санхүүжилт
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СУМ, АЙМГИЙН МАЛЧИН ӨРХИЙН ХОЛБОО, МАЛЧИН ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБОО, ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
19 дүгээр зүйл.	Сумын малчин өрхийн холбоо, түүний зохион байгуулалт
20 дугаар зүйл.	Сумын холбооны үйл ажиллагаа
21 дүгээр зүйл.	Аймгийн малчин өрхийн холбоо, түүний зохион байгуулалт
22 дугаар зүйл.	Аймгийн холбооны үйл ажиллагаа
23 дугаар зүйл.	Малчин өрхийн нэгдсэн холбоо, түүний зохион байгуулалт
24 дүгээр зүйл.	Нэгдсэн холбооны үйл ажиллагаа
25 дугаар зүйл.	Малчин өрхийн холбоонд хориглох үйл ажиллагаа
ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД	
26 дугаар зүйл.	Малчин өрхийн холбооноос төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах
27 дугаар зүйл.	Малчин өрхийн холбоонд төрөөс үзүүлэх дэмжлэг
28 дугаар зүйл.	Холбоог өөрчлөх, татан буулгах
29 дүгээр зүйл.	Холбооны тайлан
30 дугаар зүйл.	Хууль хүчин төгөлдөр болох хугацаа

Холбогдох хууль тогтоомж:

www.legalinfo.mn цахим сангаас “малчин”, “малчид”, “Малчин өрх”, “Хоршоо” “мал” гэсэн үг, тэдгээрийн хувирлаар хуультай холбогдох дараах хууль тогтоомж, эрх зүйн акт байна. Үүнд:

Хүснэгт 21

Хууль тогтоомж	Тоо
Хууль	11
УИХ-н тогтоол	3
ЗГ-ын Тогтоол	56
УДШ-ийн тайлбар	0
Үндсэн хуулийн цэцийн шийдвэр	0
УИХ-аас томилогддог байгууллагын шийдвэр	14

1.Давхардал

7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;

Хүснэгт 22

№	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
1.	3.1.Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд малчдын оролцоог хангах, малчин өрхийн холбооны тогтолцоог өөрөө удирдах ёсны зарчимд нийцүүлэн зохион байгуулахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.	45.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан нутгийн иргэдэд байгалийн нөөцийг дундаа хариуцан хамгаалах, зохистой ашиглах болон нөхөн сэргээх эрхийг олгож, нутгийн иргэд нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс нийгэм, эдийн засгийн ашиг тусыг хүртэж байх үйл явцыг байгалийн нөөцийн хамтын менежмент гэнэ.
2.	3.3.Бэлчээрийг гэрээгээр ашиглахтай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Газрын тухай хуулиар зохицуулна.	46.1.3/тухайн шатны төрийн байгууллага, иргэдийн нөхөрлөл байгалийн нөөцийн менежментийг явуулах эрх, үүргийг тэдгээрийн хооронд байгуулсан хамтын гэрээгээр энэ хуулийн хүрээнд тодорхойлсон байх;

3.	10.1.Анхдагч холбоо нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр дараах үйл ажиллагаанд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ:	48.1.Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд дараах талууд оролцоно: 1/энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалтад заасан хэлбэрээр байгуулагдсан нөхөрлөл; 2/нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга;
4.	8.1.2.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;	50.1.Байгалийн нөөцийн хамтын менежментийн үйл ажиллагаанд тухайн орон нутгийн иргэд энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдан оролцож болох бөгөөд гэрээний үндсэн дээр хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах давуу эрхтэй байна.
5.	16.5.Бүх гишүүдийн хуралд оролцох малчин өрхийн төлөөлөл нь эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна.	50.2.Иргэдийн нөхөрлөлийн гишүүн нь 18 нас хүрсэн, тухайн сум дүүрэгт байнга оршин суугч Монгол Улсын иргэн байна.

Дүгнэлт: Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зорилго, зохицуулах харилцаа нь олон талаараа Байгаль хамгаалах тухай хуульд заасан Байгалийн нөөцийн хамтын менежментийн зүйл заалтуудтай төстэй харилцааг зохицуулж байна. Тухайлбал, малчин өрхийн анхдагч холбоо сумын удирдлагатай гэрээ байгуулан гэрээний үндсэн дээр бэлчээрийг зохистой ашиглах бол хамтын менежментийн нөхөрлөл нь хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах зохицуулалттай.

Нөгөөтэйгүүр, малчин өрхийн анхдагч холбоо болон байгалийн менежментийн нөхөрлөл нь ямар түвшинд хоорондоо харилцах, эдгээрийн хооронд гарсан аливаа асуудлыг сум, аймгийн түвшинд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгах нь зүйтэй байна.

2.Зөрчил

7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

Хүснэгт 23

№	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
1.	1.2.Энэ хуулийн зорилт нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 23.1.Аймгийн малчин өрхийн холбоод нэгдэж, улсын хэмжээнд малчин өрхийн нэгдсэн холбоог /цаашид "нэгдсэн холбоо" гэх/ байгуулна.
Дүгнэлт: Хуулийн үзэл баримтлалын хүрээнд үзэхэд малчин өрхийн хамтын менежментийн суурь нэгж нь Малчин өрхийн анхдагч холбоо юм. Харин хуулийн нэрийг эдгээр холбооны нэгдсэн холбооны тухай хууль байдлаар нэрлэсэн нь хуулийн зорилгоос зөрүүтэй байна. Хуулиар анхдагч холбоо болон нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг тогтоосон хэдий ч дээр дурдсанчлан малчдын хоршлыг дэмжих нь гол харилцаа тул хуулийн нэрийг ерөнхийлөн Малчин өрхийн холбооны тухай хууль гэж нэрлэх нь үзэл баримтлалтайгаа нийцтэй байна.	

7.2.7.хуульд заасан ишлэл алдаатай эсэх;

Хүснэгт 24

№	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн эшлэл бүхий зохицуулалт	Эшлэл, эшлэлийн дугаар алдаатай эсэх
1.	4.1.1."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;	Үгүй
2.	7.2.Анхдагч холбоог үүсгэн байгуулах хурлыг энэ хуулийн 7.1-д заасан малчин өрхийн төлөөлөл зохион байгуулж, уг хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:	Үгүй
3.	9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.	Үгүй. Холбогдох хууль нь тодорхойгүй.
4.	10.1.4.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг Газрын тухай хуулийн 21.4.5, 21.4.6-д заасны дагуу ашиглуулахад хяналт тавих;	Үгүй
5.	10.1.6.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7.5.1, 7.5.2, 7.5.3-т заасан шаардлагыг хангасан, халдварт өвчний шинж тэмдэг илрээгүй мал оруулах, дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих;	Үгүй

6.	10.2.Газрын тухай хуулийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалж болно.	Үгүй
7.	18.2.1.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаа;	Үгүй
8.	20.1.2.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд сумын түвшинд баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, энэ талаарх саналаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;	Үгүй
9.	20.1.7.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд гишүүд, бусад аймаг, сумын холбооны сайн туршлага, үйлдвэрлэлийн шинэ арга технологийг зөвлөн нэвтрүүлэх үйлчилгээг зохион байгуулах.	Үгүй
10.	21.3.Аймгийн холбоог үүсгэн байгуулах хурлаар энэ хуулийн 19.3.1, 19.3.2, 19.3.3-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.	Үгүй
11.	22.1.2.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд аймгийн түвшинд баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;	Үгүй
12.	23.3.Нэгдсэн холбоог үүсгэн байгуулах хурлаар энэ хуулийн 19.3.1, 19.3.2, 19.3.3-т заасан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.	Үгүй
13.	29.2.Холбоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу татварын тайлан гаргаж, харьяа татварын албанд тайлагнана.	Үгүй
14.	29.3.Холбоо албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаандаа Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасан албан хэрэг хөтлөлт болон байгууллагын архивт баримтлах журмыг мөрдөнө.	Үгүй
Дүгнэлт: Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд алдаатай эшлэл байхгүй байна.		

7.2.13.Тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

Хүснэгт 25

№	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2.	4.1.4."байгалийн нөөц" гэж гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн ургамал, уст цэг, ан амьтан зэргийг.	5 дугаар зүйл.Ургамал ашигласны төлбөр ногдох зүйл 6 дугаар зүйл.Ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл 7 дугаар зүйл.Ойн нөөц ашигласны төлбөр ногдох зүйл

		8 дугаар зүйл.Ан амьтны нөөц ашигласны төлбөр ногдох зүйл
Дүгнэлт: Байгалийн нөөц буюу Natural resource гэдэг нь хүний гараар бүтээгдээгүй, байгальд байдаг ус, хөрс, ургамал, амьтан зэрэг хүний хэрэгцээнд ашиглах эх үүсвэр болдог зүйлийг өргөн утгаар хэлдэг. Гэвч Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд байгалийн нөөцийг гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн ургамал, уст цэг, ан амьтан зэргийг гэж хумьж тодорхойлсон байна. Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар төлбөр ногдох зүйлд ургамал, ус, рашааны нөөц, ойн нөөц, ан амьтны нөөц зэргээр өргөн хүрээгээр заажээ.		

3.Хийдэл

7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;

Хүснэгт 26

№	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
1.	9.1.1.нарийн мэргэжлийн болон эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээ авах хүсэлтийг сумын эрүүл мэндийн төвд уламжилж, хамтран ажиллах; 9.2.Энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.
Дүгнэлт: Дээрх заалтуудын хувьд ямар хуулиар 9.1.1, 9.1.2-т заасан харилцааг цаашид зохицуулах гэдэг нь тодорхойгүй байна. Мөн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд “7.4.Иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндтэй холбоотой асуудлаар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчид хандах бөгөөд эмчийн заавар, чиглэлээр эрүүл мэндийн холбогдох бусад байгууллагад хандана.” гэж заасны дагуу малчид, иргэд өөрсдөө холбогдох эмнэлгийн байгууллагадаа хандах эрхтэй. Малчин өрхийн холбоо энэхүү харилцаанд ямар үндэслэлээр холбооны гишүүний өмнөөс мэргэжлийн болон эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээ авах хүсэлтийг сумын эрүүл мэндийн төвд уламжилж байгаа болон хэрхэн хамтран ажиллах нь тодорхойгүй.	

7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;

Хүснэгт 27

№	Журам батлах эрх олгсон зохицуулалт	Холбогдох журам батлагдсан эсэх
2.	Газрын тухай хуулийн 52.12-т Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээр	Батлагдаагүй.

	ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.	Тайлан боловсруулах хугацааны байдлаар уг журам болон гэрээний загварын төслийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ хамтран боловсруулахаар санамж бичиг байгуулсан байна.[6]

7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;

Хүснэгт 28

№	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
3.	15.6.Гишүүнчлэлээс гаргасантай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх журмыг дүрэмд зааж болно.
Дүгнэлт: Бүх гишүүдийн хурлаас гишүүнчлэлээс гаргасан бол тухайн шийдвэрт гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх зохицуулалтын талаар дүрэмд заахыг хуульчлах нь зүйтэй. Учир нь гишүүний төлсөн хураамж, дундын өмчлөлийн гэх мэт эрхийн болон өмчлөлийн асуудал үүсэх боломжтой бөгөөд эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар хуульд тодорхой зохицуулалт хийж шийдвэрлэх нь нийцтэй байна.	
4.	26.2.Аймгийн болон сумын холбоо нь орон нутгийн зохих шатны удирдлагад холбооны үйл ажиллагааны тайланг танилцуулна.
Дүгнэлт: Үйл ажиллагааны тайланг танилцуулах хугацааг аймаг, сумаар ялгаатай, тодорхой тогтоосноор үйл ажиллагаа нээлттэй, хариуцлагатай бөгөөд энэ заалт хэрэгжих гол нөхцөл болно.	
5.	24.1.6.холбооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх.
Тус хуулиар нэгдсэн холбоо нь холбооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх чухал үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан боловч үүнтэй холбоотой нарийвчилсан харилцааг тусгаагүй.	
6.	Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага
Хууль тогтоомжийн тухай хуулиар хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах шаардлагыг тавьдаг. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, сэргээх, гэрээний үүргээ сахин биелүүлэх зэрэг үүргээс гадна холбооны үйл ажиллагаа, түүний тайланд тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг оруулаагүй нь энэхүү хууль нь эрх зүйн талаасаа чадваргүй, зөвхөн тунхгийн шинжтэй баримт бичиг болох эрсдэлтэй юм.	

[6] https://greenmongolia.mn/post/163861

2.2.1.Дүгнэлт

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг шалгуур үзүүлэлтээр авч үзвэл давхардал, зөрчил, хийдэл бүхий нийт 13 зохицуулалт байгаагаас:

Хүснэгт 29

Шалгуур үзүүлэлт	Тоо
Давхардал	
7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх	5
Нийт давхардал	***5***
Зөрчил	
7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	1
7.2.13.Тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх	1
Нийт зөрчил	***2***
Хийдэл	
7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх	1
7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх	1
7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох	4
Нийт хийдэл	***6***

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль нь 2024 онд батлагдсан бөгөөд энэ нь "Малчны тухай хууль"-тай зорилго, зохицуулах харилцааны хувьд тодорхой хэмжээнд давхцаж байгаа талаар Малчны тухай хуулийн дүгнэлт хэсэгт дурдсан. Иймд эдгээр хуулийн давхардлыг арилгах зорилгоор Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн Малчны тухай хуультай давхардсан хэсгийг Малчны тухай хуулиас эшлэх замаар өөрчлөн найруулах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн "Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль" нь зохицуулах харилцааны хувьд "Байгаль хамгаалах тухай хууль"-д тусгагдсан “Байгалийн нөөцийн хамтын менежмент”-ийн зохицуулалттай олон талаараа төсөөтэй байна. Тухайлбал, малчин өрхийн анхдагч холбоо нь сумын Засаг даргатай гэрээ байгуулан, бэлчээрийг зохистой ашиглах зохицуулалттай байдаг бол, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь гэрээний үндсэн дээр тодорхой төрлийн байгалийн нөөцийг хариуцан, зохистой ашиглах үүрэгтэй байдаг. Энэ нь хоёр хуулийн харилцааны агуулга, зарчмын уялдаа, давхцалыг харуулж байна.

Иймээс Малчин өрхийн анхдагч холбоо болон байгалийн менежментийн нөхөрлөлийн хоорондын харилцааг ямар түвшинд хэрхэн зохион байгуулах, эдгээрийн хооронд үүсэх аливаа зөрчил, маргааныг сум, аймгийн түвшинд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зохицуулах нь зүйтэй.

Түүнчлэн "Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай" хуулийн нэр нь хуулийн зохицуулалтын цар хүрээ, агуулгатайгаа төдийлөн нийцэхгүй байна. Тус хууль нь ганц малчин өрхийн нэгдсэн холбоо биш малчин өрхийн холбооны эрх зүйн байдлыг тодорхойлохоос гадна хуулийн гол зорилго нь малчин өрхийн хамтын менежмент, зохион байгуулалт, хоршлын зарчимд суурилсан хамтын ажиллагааг дэмжихэд чиглэж байгаа тул, хуулийн нэрийг илүү оновчтойгоор "Малчин өрхийн холбооны тухай хууль" гэж өөрчлөх нь үзэл баримтлал, агуулга, зорилгодоо нийцэхээр байна.

Мөн хуулийн хийдэл бүхий зохицуулалтуудаас “тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох” шалгуур үзүүлэлтэд хамаарах зохицуулалт давамгайлсан. Тодруулбал, холбооны бүх гишүүдийн хурлаар гишүүнчлэлээс хасагдсан этгээд тухайн шийдвэрт гомдол гаргах, гомдлыг шийдвэрлэх, холбооны үйл ажиллагааны тайланг танилцуулах болон нэгдсэн холбооноос мэдээллийн цахим санг бүрдүүлэх, хөтлөхтэй холбоотой зохицуулалтыг тусгаагүй байна.

Цаашилбал, хуулиар бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, сэргээх, гэрээний үүргээ сахин биелүүлэх зэрэг үүргээс гадна холбооны үйл ажиллагаа, түүний тайланд тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг оруулаагүй нь энэхүү хууль нь эрх зүйн талаасаа чадваргүй, зөвхөн тунхгийн шинжтэй баримт бичиг болох эрсдэлийг бий болгож байна.

2.3. Хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/

Энэхүү хуулийн зорилт нь хоршоог үүсгэн байгуулах, хоршооны гишүүнчлэл, удирдлага, зохион байгуулалт, хөрөнгө, хяналт, үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Нийт 8 бүлэг, 56 зүйлтэй. УИХ-аас 2021 оны 05 сарын 06-ны өдөр баталсан.

Хүснэгт 30

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	
1 дүгээр зүйл.	Хуулийн зорилт
2 дугаар зүйл.	Хоршооны хууль тогтоомж
3 дугаар зүйл.	Хуулийн үйлчлэх хүрээ
4 дүгээр зүйл	Хуулийн нэр томьёоны тодорхойлолт
5 дугаар зүйл	Хоршооны үйл ажиллагаанд баримтлах зарчим
6 дугаар зүйл	Хоршооны хэлбэр, үйл ажиллагааны чиглэл
ХОЁРДУГААР БҮЛЭГ ХОРШООГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ	
7 дугаар зүйл.	Хоршооны оноосон нэр, оршин байгаа газар
8 дугааар зүйл.	Үүсгэн байгуулах гэрээ
9 дүгээр зүйл.	Хоршоог улсын бүртгэлд бүртгүүлэх
10 дугаар зүйл.	Хоршооны дүрэм, түүний агуулга
11 дүгээр зүйл.	Хоршооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах
12 дугаар зүйл.	Хоршооны эрх, үүрэг
13 дугаар зүйл.	Хоршооны хариуцлага
ГУРАВДУГААР БҮЛЭГ ХОРШООНЫ ГИШҮҮН	
14 дүгаар зүйл.	Хоршоонд элсэх
15 дугаар зүйл.	Хоршооны гишүүний бүртгэл хөтлөх
16 дугаар зүйл.	Хоршооны гишүүний бүртгэлтэй танилцах
17 дугаар зүйл.	Хоршооны гишүүний эрх, үүрэг

18 дугаар зүйл.	Хоршооны гишүүний бүрэн эрх дуусгавар болох
19 дүгээр зүйл.	Хоршооны гишүүний бүрэн эрх дуусгавар болсон этгээдтэй санхүүгийн тооцоо хийх
20 дугаар зүйл.	Оруулсан хувь хөрөнгөө бусдад шилжүүлэх
21 дүгээр зүйл.	Хоршооны гишүүний эд хөрөнгийн эрх өв залгамжлагчид шилжих
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХОРШООНЫ ХӨРӨНГӨ, ЭХ ҮҮСВЭР	
22 дугаар зүйл.	Хоршооны өөрийн хөрөнгө
23 дугаар зүйл.	Хоршооны хөрөнгө, эх үүсвэрийг бүртгэх
24 дүгээр зүйл.	Хоршоонд гишүүний оруулсан хувь хөрөнгө
25 дугаар зүйл.	Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хөрөнгө хуваарилах
26 дугаар зүйл.	Хоршооны гишүүнд ногдох орлого хуваарилах
27 дугаар зүйл.	Хоршооны хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлэх
28 дугаар зүйл.	Хоршоог дэмжих хөрөнгө оруулалт
ТАВДУГААР БҮЛЭГ ХОРШООНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	
29 дүгээр зүйл.	Хоршооны эрх барих байгууллага
30 дугаар зүйл.	Бүх гишүүдийн хурал
31 дүгээр зүйл.	Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах этгээд
32 дугаар зүйл.	Бүх гишүүдийн хурал хуралдах хугацаа, газар
33 дугаар зүйл.	Бүх гишүүдийн хурлыг зарлах, бэлтгэл ажлыг хангах
34 дүгээр зүйл.	Хоршооны Тэргүүлэгчид
35 дугаар зүйл.	Тэргүүлэгчдийн хариуцлага
36 дугаар зүйл.	Хоршооны дарга
37 дугаар зүйл.	Хяналтын зөвлөл
38 дугаар зүйл.	Хяналтын зөвлөлийн хуралдаан
39 дүгээр зүйл.	Хяналтын зөвлөлийн бүрэн эрх
40 дүгээр зүйл.	Хяналтын зөвлөлийн гишүүн

41 дүгээр зүйл.	Хоршооны гүйцэтгэх удирдлага
ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХОРШООНЫ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, ХОРШООЛЛЫН НЭГДСЭН БА ХОРШООДЫН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХ	
42 дугаар зүйл.	Хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
43 дугаар зүйл.	Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх
44 дүгээр зүйл.	Хоршоодын холбоо
45 дугаар зүйл.	Хоршоодын холбооны чиг үүрэг
46 дугаар зүйл.	Хоршоollын нэгдсэн холбоо
ДОЛДУГААР БҮЛЭГ ХОРШООГ ТАТАН БУУЛГАХ	
47 дугаар зүйл.	Хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгах
48 дугаар зүйл.	Хоршоог шүүхийн шийдвэрээр татан буулгах
49 дүгээр зүйл.	Хоршоо татан буугдсаныг мэдэгдэх
50 дугаар зүйл.	Татан буулгах комисс томилох, татан буулгах
51 дүгээр зүйл.	Татан буулгах комиссыг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх
52 дугаар зүйл.	Татан буулгах комисс хоршоог төлөөлж гарын үсэг зурах
53 дугаар зүйл.	Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсноос хойш хоршооны гишүүний үүргийг нэмэгдүүлэхгүй байх
54 дүгээр зүйл.	Хөрөнгө хуваарилахыг хориглох хугацаа
55 дугаар зүйл.	Хоршооны эд хөрөнгийг гишүүдэд хуваарилах
НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД	
56 дугаар зүйл.	Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Холбогдох хууль тогтоомж:

www.legalinfo.mn цахим сангаас “Хоршоо” гэсэн үг, тэдгээрийн хувирлаар хуультай холбогдох дараах хууль тогтоомж, эрх зүйн акт байна. Үүнд:

Хүснэгт 31

Хууль тогтоомж	Тоо
Хууль	3
УИХ-н тогтоол	3
ЗГ-ын Тогтоол	7
УДШ-ийн тайлбар	1
Сайдын тушаал	5
УИХ-аас томилогддог байгууллагын шийдвэр	0

1.Давхардал

7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;

Хүснэгт 32

№	Хоршооны тухай хууль	Иргэний хууль
1.	50.1.Хоршоог татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32.2-т заасныг үндэслэн энэ тухай шийдвэр гаргасан этгээдийн томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.	32.2.Татан буулгах ажлыг энэ тухай шийдвэр гаргасан байгууллагаас томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.
2.	49.2.Хоршоо татан буугдсаныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн тухай татан буулгах комисс нийтэд мэдээлнэ.	32.3.Татан буулгах комисс нь хуулийн этгээд татан буугдсан тухай нийтэд мэдээлнэ.
3.	49.3.Хоршооноос авлагатай этгээдэд хоршоо татан буугдсан тухай тусгайлан мэдэгдэнэ.	32.4.Татан буулгах комиссоос нэхэмжлэгчдийн өргөдөл хүлээн авах хугацаа нь хуулийн этгээдийг татан буугдсан тухай нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас ихгүй байна.
Дүгнэлт: Суурь хууль болох Иргэний хуулийн зохицуулалттай агуулгын хувьд давхардсан.		

2.Зөрчил

7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;

Хүснэгт 33

№	Хоршооны тухай хууль
1.	**51 дүгээр зүйл.Татан буулгах комиссыг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх**

	51.1.Татан буулгах комиссын гишүүдийг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хүргүүлнэ.
Дүгнэлт: Зүйлийн гарчигт татан буулгах комиссыг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэхээр байгаа боловч зүйлийн заалт нь татан буулгах комиссын гишүүдийг хүргүүлэхээр заажээ.	

7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгагүй, ойлгомжтой байгаа эсэх;

Хүснэгт 34

№	Хоршооны тухай хууль
2.	25.4.Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ нь хоршооны сүүлийн гурван жилийн борлуулалтын орлогын дунджийн 20 хувиас хэтрэхгүй байна.
Дүгнэлт: Болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн заавал байлгах хөрөнгийн хэмжээний хамгийн бага хязгаарыг хуульчлан тогтоож, харин дээд хэмжээг хоршоо өөрөө дүрмээрээ зохицуулдаг байхаар өөрчлөх нь зүйтэй.	

7.2.5.хуульд тодорхойлсон нэр томьёог бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байгаа эсэх;

Хүснэгт 35

№	Хоршооны тухай хууль
3.	10.3.14.хоршооны гишүүнд ногдох орлого хуваарилах, оруулсан хувь хөрөнгийг буцаан олгох журам; 23.1.Хоршооны хөрөнгө, эх үүсвэрийг энэ хуульд заасан журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэнэ.
Дүгнэлт: “Хувь хөрөнгө” гэсэн хөрөнгийн талаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд байхгүй. Харин Нөхөрлөлийн тухай хуульд “хувь хөрөнгө” гэж байгаа. Хоршооны гишүүний оруулсан хөрөнгө, нийлүүлсэн хөрөнгө зэргээр өөрчлөлт оруулах боломжтой.	

7.2.7.хуульд заасан эшлэл алдаатай эсэх;

Хүснэгт 36

№	Хоршооны тухай хуулийн эшлэл бүхий зохицуулалт	Эшлэл, эшлэлийн дугаар алдаатай эсэх
1.	4.1.1."хоршоо" гэж Иргэний хуулийн 36.4-т заасан хуулийн этгээдийг;	Үгүй.

2.	4.1.8.“гарын үсэг” гэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.14-т заасныг.	Үгүй.
3.	11.4.Хоршооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хоршооны гишүүн энэ хуулийн 17.1.12-т заасны дагуу хоршооноос гарах эрхээ эдэлж болно.	Үгүй.
4.	16.3.Энэ хуулийн 16.2-т заасны дагуу хоршооны гишүүний бүртгэлтэй холбоотой мэдээлэл авсан этгээд уг мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.	Үгүй
5.	18.5.Энэ хуулийн 18.4-т заасан үндэслэл бий болсон тохиолдолд Тэргүүлэгчид энэ тухай хоршооны гишүүнд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр урьдчилан мэдэгдэж, тайлбар хийх боломж олгоно.	Үгүй.
6.	24.3.Хоршооны гишүүний хоршоонд оруулах хувь хөрөнгийн хэлбэр, хэмжээг хоршооны дүрмээр энэ хуулийн 24.2-т заасны дагуу тогтооно.	Үгүй.
7.	27.2.Энэ хуулийн 26.1-д заасны дагуу хоршооны гишүүнд ногдох орлогыг хуваарилсны дараах орлогоос Хоршооны хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлнэ.	Үгүй.
8.	30.10.Бүх гишүүдийн хуралд биечлэн оролцох боломжгүй болсон хоршооны гишүүн хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан энэ хуулийн 17.1-д заасан эрхээ хэрэгжүүлнэ.	Үгүй.
9.	31.2.Тэргүүлэгчид бүх гишүүдийн хурлыг энэ хуулийн 32.1, 34.8-д заасны дагуу хуралдуулаагүй бол Хяналтын зөвлөл зарлан хуралдуулна.	Үгүй.
10.	31.4.Энэ хуулийн 31.3-т заасан бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах санаачилга гаргагч нь бүх гишүүдийн хурлыг хуралдуулах үндэслэл, шалтгаан, хэлэлцэх асуудлын саналаа бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргаж, гарын үсгээр баталгаажуулан хоршооны гишүүдэд мэдэгдэнэ.	Үгүй.
11.	34.7.Хагас жилийн болон жилийн тайлан гаргахад, эсхүл баримжаалсан тооцоогоор алдагдал гарч, түүнийг энэ хуулийн 25.2-т заасны дагуу болзошгүй эрсдэлээс хамгаалах сангийн хөрөнгөөс нөхөх шаардлага үүсвэл Тэргүүлэгчид энэ тухай хоршооны гишүүдэд мэдэгдэнэ.	Үгүй.
12.	47.2.Хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгах тохиолдолд бүх гишүүдийн хурлаас татан буулгах комисс томилно. Татан буулгах комисс Иргэний хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу татан буулгах ажиллагааг хийнэ.	Үгүй.

13.	48.1.1.Иргэний хуулийн 32.1-д заасан нөхцөл бий болсон;	Иргэний хуулийн 32.1-т хуулийн этгээдийг татан буулгах 5 үндэслийг дурдсан бөгөөд үүнээс 2 үндэслэлийг шүүх ашиглах боломжтой байна.
14.	49.1.Хоршоог татан буулгах шийдвэр гаргасан эрх бүхий этгээд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23.1-д заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.	Үгүй.
15.	50.1.Хоршоог татан буулгах ажлыг Иргэний хуулийн 32.2-т заасныг үндэслэн энэ тухай шийдвэр гаргасан этгээдийн томилсон комисс эрхлэн гүйцэтгэнэ.	Үгүй.
16.	54.1.Хоршооны өр төлбөртэй холбоотой нэхэмжлэлийг Иргэний хуулийн 32.5-д заасан дарааллаар барагдуулна.	Үгүй.
17.	55.5.Энэ хуулийн 55.4-т заасан хэмжээг хоршооны дүрмээр өөрөөр тогтоож болно.	Үгүй.
Дүгнэлт: Хоршооны тухай хуулинд алдаатай 1 эшлэл байна.		

3.Хийдэл

7.3.2. тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;

Хүснэгт 37

№	Журам батлах эрх олгосон зохицуулалт	Батлагдсан эсэх
1.	42.1.7.улсын шилдэг хоршоог шалгаруулах, шагнах журмыг батлах;	**Батлагдсан.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А-295 дугаар тушаалын хавсралт “Улсын шилдэг хоршоо шалгаруулах, шагнах журам”-ыг баталсан.
2.	42.1.9.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг батлах, уг сангийн зарцуулалтад хяналт тавих, нэгдсэн бодлого, удирдлагаар хангах;	**Батлагдсан.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ыг баталсан.

Дүгнэлт: Хуулиар журам батлах эрх олгосон этгээдээс холбогдох журмуудыг баталж, хүчин төгөлдөр үйлчилж байна.

7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;

Хүснэгт 38

№	Хоршооны тухай хууль
1.	42.1.Хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хоршооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 42.1.4.хоршооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх; 46.2.Хоршооллын нэгдсэн холбоо дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна: 46.2.7.гишүүн холбоод, тэдгээрийн гишүүн хоршоодын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл өгөх.
Дүгнэлт: Хуулийн 42.1.4 дэх заалтаар хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хоршооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх бүрэн эрхтэйгээр заасан боловч Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн хоршооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх тусгайлан эрх олгосон заалт оруулаагүй. Хоршооны мэдээллийн цахим санг хэрхэн бүрдүүлэх, хадгалах, дамжуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах зэрэг асуудлыг тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлагдсанаар хуулийн энэхүү заалтаар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх нөхцөл үүснэ. Мөн хуулийн 46.2.7 дахь хэсгээр хоршооллын нэгдсэн холбоо нь гишүүн холбоод, тэдгээрийн гишүүн хоршоодын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мэдээлэл өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар заасан боловч мэдээллийн санг хэрхэн бүрдүүлэх, хадгалах, дамжуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулаагүй байна.	
2.	56.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
Дүгнэлт: Зөрчлийн тухай хуулийн 10.10 дугаар зүйл.Хоршооны тухай хууль зөрчих гэсэн зүйлд 1.Хоршооны тухай хууль зөрчиж дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх журам зөрчсөн, эсхүл дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан. Гэтэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу энэ зөрчилд Улсын бүртгэлийн хяналтын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалттай. Өөрөөр хэлбэл Хоршооны тухай хуульд заасан өөр зохицуулалтыг зөрчсөнөөс үүсэхтэй холбоотой асуудлыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээргүй байна.	

Түүнчлэн, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан хэдий ч Хоршооны үүргийг биелүүлээгүй этгээдэд авах арга хэмжээ Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль аль альд тусгагдаагүй. Хяналтын процедур тодорхойгүй байна.

2.3.1.Дүгнэлт

Хоршооны тухай хуулийг шалгуур үзүүлэлтээр авч үзвэл давхардал, зөрчил, хийдэл бүхий нийт 9 зохицуулалт байгаагаас:

Хүснэгт 39

Шалгуур үзүүлэлт	Тоо
Давхардал	
7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх	3
Нийт давхардал	***3***
Зөрчил	
7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх	1
7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгагүй, ойлгомжтой байгаа эсэх	1
7.2.5.хуульд тодорхойлсон нэр томьёог бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байгаа эсэх	1
7.2.7.хуульд заасан эшлэл алдаатай эсэх	1
Нийт зөрчил	***4***
Хийдэл	
7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	2
Нийт хийдэл	***2***

Судалгааны үр дүнгээр Хоршооны тухай хуулийн давхардал, зөрчил, хийдэл бүхий зохицуулалт хамгийн бага байсан бөгөөд үүнээс давхардал болон зөрчилд хамаарах зохицуулалт нь ач холбогдлын хувьд бага, зөвхөн хууль зүйн техникийн шинжтэй өөрчлөлт шаардлагатай гэж үзэж байна.

Харин Хоршооны тухай хуулиар хоршооны үйл ажиллагааны чиглэлийг өргөн хүрээтэй буюу хоршоо нь хууль тогтоомжоор хориглоогүй, хоршооны дүрэмд заасан үйл ажиллагаа явуулахаар заасан боловч Хоршооны тухай хуулийг зөрчсөн зөрчлийг зөвхөн Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагчид хамааруулсан нь уг хуулийн хэрэгжилтийг хангуулахад эрсдэл үүсгэхээр байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хууль хоорондын давхардлыг арилгах хүрээнд:

Малчны тухай хууль болон Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль нь Монгол Улсын малчдын эрх зүйн байдлыг анх удаа тусгайлан зохицуулсан, шинэлэг бөгөөд стратегийн ач холбогдолтой хууль юм. Энэхүү хууль нь Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын үргэлжлэл төдийгүй, малчдын нийгэм, эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, тогтвортой амьжиргааг бий болгоход чиглэсэн эрх зүйн үндсийг бүрдүүлж байна.

Гэвч эдгээр хуулиудын зорилго, зорилт нь малчид хоорондын хамтралыг дэмжих замаар мал аж ахуйгаа хөгжүүлэх, улмаар малчдын хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлэх хүрээнд давхацдаг бөгөөд байгалийн нөөц, бэлчээрийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын эрүүл мэндийг хамгаалах, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой зохицуулалтуудыг давхардуулан зохицуулсан нь хууль хоорондын уялдаа холбоог алдагдуулж байна.

Цаашид Малчны тухай хууль болон Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан зорилго, зорилтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд дараах санал, зөвлөмжийн дэвшүүлж байна.

1. “Малчны тухай хууль” болон "Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай" хуулийг нэгтгэн бусад хуулиудтай нийцтэй, уялдаатай байдлаар боловсруулж, батлуулах замаар малчдын эрх зүйн орчныг илүү цогц, үр ашигтай болгон хөгжүүлэх.
   эсхүл
2. Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн Малчны тухай хуультай давхардсан хэсгийг Малчны тухай хуулиас эшлэх замаар өөрчлөн найруулах. Жишээлбэл, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1 дэх хэсгийг “Анхдагч холбоо нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр Малчны тухай хуулийн 5.3.2-т зааснаас гадна дараах үйл ажиллагаанд Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлнэ.” гэж өөрчлөх.

2. Хуулийн хийдлийг арилгах хүрээнд:

Малчны тухай хууль, түүнийг дагалдан гарсан хуулиудад малчин, малчдын хамтын санаачилга, хоршилд гэрээгээр бэлчээр ашиглуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаагүй нь малчин өрхийн холбоонд хамаарахгүй малчин болон малчны хамтын санаачилга, хоршил нь малчин өрхийн

холбоонд нэгдэх замаар бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахаас аргагүй байдалд хүрэх, улмаар сайн дурын үндсэн дээр малчин өрхийн холбоонд элсэх суурь зарчим гажуудах эрсдэлийг бий болгож байна.

Мөн Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд хуулиар бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, сэргээх, гэрээний үүргээ сахин биелүүлэх зэрэг үүргээс гадна холбооны үйл ажиллагаа, түүний тайланд тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг оруулаагүй нь энэхүү хууль нь эрх зүйн талаасаа чадваргүй, зөвхөн тунхгийн шинжтэй баримт бичиг болох эрсдэлийг бий болгож байна.

Түүнчлэн Хоршооны тухай хуулиар хоршооны үйл ажиллагааны чиглэлийг өргөн хүрээтэй буюу хоршоо нь хууль тогтоомжоор хориглоогүй, хоршооны дүрэмд заасан үйл ажиллагаа явуулахаар заасан боловч Хоршооны тухай хуулийг зөрчсөн зөрчлийг зөвхөн Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагчид хамааруулсан нь уг хуулийн хэрэгжилтийг хангуулахад эрсдэл үүсгэж байна.

Иймд дээрх хуулиудын хийдлийг арилгах хүрээнд дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Малчны тухай хуульд малчин, малчны хамтын санаачилга, хоршлын гэрээгээр бэлчээр ашиглах эрхийг баталгаажуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг нэмэлтээр оруулах;
2. Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуульд уг хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах;
3. Хоршооны тухай хуулийг зөрчсөн зөрчлийг хоршооны үйл ажиллагааны чиглэлээс хамаарч тухайн салбарын улсын байцаагч хянан шийдвэрлэх зохицуулалтыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон холбогдох хуульд тусгах.

Мөн Малчны тухай хуулийг бодит амьдралд хэрэгжүүлэх, үр нөлөөг нь дээшлүүлэх үүднээс хуульд тусгагдсан арга хэмжээ, бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон захиргааны хэм хэмжээний актуудыг Засгийн газар нэн даруй боловсруулж, батлан мөрдүүлэхыг зөвлөж байна. Ингэснээр хууль хэрэгжих явцад үүсч болзошгүй тодорхой бус байдал, хэрэгжилтийн доголдлыг бууруулах, хуулийн зорилгоо бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзэж байна.

3. Хуулийн зөрчлийг арилгах хүрээнд:

Малчны тухай хуулийн тавдугаар бүлэг нь малчны хамтын санаачилгыг дэмжих нэртэй боловч мөн хуулийн 10.1 дэх хэсэгт малчны хамтын санаачилга, хоршлын хэлбэрийг, 10.4 дэх хэсэгт “Төрөөс малчны хамтын санаачилга, хоршлыг дэмжих” байдлыг заасан. Өөрөөр хэлбэл, тус бүлэг нь малчны хамтын санаачилга,

хоршлыг дэмжихтэй холбоотой харилцааг зохицуулж байх тул бүлгийн нэр агуулгатай зөрчилдөж байна.

Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт нь малчин өрхийн холбооны зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршихоор заасан бөгөөд малчин өрхийн холбоо нь малчин өрхийн анхдагч холбоо, сумын, аймгийн, нэгдсэн холбооны зохион байгуулалттай байхаар заасан. Иймд, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн нэр нь хуулийн үйлчлэх хүрээтэй зөрчилдөж байна.

1. Малчны тухай хуулийн тавдугаар бүлгийн нэрийг “Малчны хамтын санаачилга, хоршлыг дэмжих” гэж өөрчлөх,
2. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн нэрийг “Малчин өрхийн холбооны тухай хууль” болгон өөрчлөх.

___o0o___

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Малчны тухай хууль *(Төрийн мэдээлэл эмхэтгэл 2024, №24)*
2. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль *(Төрийн мэдээлэл эмхэтгэл 2024, №24)*
3. Хоршооны тухай хууль *(Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021, №21)*
4. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол
5. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 63 дугаар тогтоол
6. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоол
7. Малчны тухай хуулийн төслийн үзэл баримтал, танилцуулга, судалгаа
8. Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, судалгаа
9. Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга, тандан судалгаа

Хавсралт 1

Судлагдсан хуулиудын давхардал, зөрчил, хийдлийн нэгдсэн мэдээлэл

	№	Малчны тухай хууль	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль	Хоршооны тухай хууль
Давхардал	7.1.1.тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;	Малчны тухай хуулийн 3.1.3."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг;3.1.4."туслах малчин" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 71.2-т заасан тодорхйололот гэсэн тодорхойлолт уг хуулийн гол эзэн болох малчны тодорхойлолтыг бусад хуулиас эшлэж ашигласан нь хуулийн зорилготой бүрэн нийцэхгүйгээс гадна хууль хэрэглээний хувьд шаардлаггүй хүндрэлийг бий болгож байна. Үүний оронд, Малчны тухай хуульд “малчин”, “туслах малчин” тодорхойлолтыг тусган бусад хуульд уг хуулиас эшлэлийг авч тусгах нь зохистой байна. Мөн уг хуульд “мал”-ын тодорхойлолтыг оруулж, Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд Малчны тухай хуулиас эшлэх нь зохистой байна.	-	-
	7.1.2.тухайн хуульд байгаа зохицуулалтыг бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;	Малчны тухай хууль, Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн хуулийн зорилт, зорилгын заалтууд нь агуулгын хувьд давхардсан байна. Тухайлбал, малчны эрх зүйн байдлыг тодорхойлж, малчид хоорондын хамтрал, мал аж ахуйгаа хамтран хөгжүүлэх, улмаар байгалийн нөөц, бэлчээрийн зохистой ашиглалт, уламжлалыг хадгалан хамгаалах, малчны амьдралын чанарыг сайжруулах нь 2 хуулийн үндсэн зорилго байна. Иймд энэ 2 бие даасан хуулийг нэгтгэн Малчны тухай хууль болгон нэг цогц хуулиар үндсэн		Хоршооны тухай хуулийн 50.1, 49.2, 49.3 дахь заалтууд Иргэний хуулийн 32.2-32.4 дэх хэсгүүдийн зохицуулалттай давхцаж байна. Суурь харилцааг зохицуулж байгаа хууль нь Иргэний хууль тул тухайн

		зорилгынхоо хүрээнд бусад харилцааг тусган хуульчлахх боломжтой бөгөөд хуулийн хэрэглээний хувьд илүү хялбар болох юм. Мөн Малчны тухай хуулиар малчин нь байгалийн нөөц, бэлчээр, усан хангамжийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын эрүүл мэндийг хамгаалах, малын генетик нөөцийг зохистой ашиглах, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр заасан бол Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоо нь гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын чанар, ашиг шимийг сайжруулах, эрүүл мэндийг хамгаалах, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулах үйл ажиллагаанд гишүүдийн зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхээр заасан. Малчин өрхийн анхдагч холбооны гишүүн нь малчин өрх байх бөгөөд малчин өрхийн гишүүн нь малчин юм. Өөрөөр хэлбэл, Малчны тухай хуулиар малчин өрхийг бий болгож байгаа малчин байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, малын эрүүл мэндийг хамгаалах, малын гараглтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зэрэг үүргийг хүлээсэн байхад Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоо нь эдгээр үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд гишүүдийг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэхээр давхардуулан зохицуулсан байна. Иймд, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд Малчны тухай хуульд заасан зохицуулалтыг давхардуулахгүйгээр, эшлэх замаар өөрчлөлт оруулж, давхардлыг арилгах шаардлагатай байна.		хуулийн зохицуулалтыг заах байдлаар Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах боломжтой.
		-	Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зорилго, зохицуулах харилцаа нь олон талаараа Байгаль хамгаалах тухай хуульд заасан **Байгалийн нөөцийн хамтын менежментийн зүйл заалтуудтай** төстэй харилцааг зохицуулж байна. Тухайлбал, малчин өрхийн анхдагч холбоо сумын удирдлагатай гэрээ байгуулан гэрээний үндсэн дээр бэлчээрийг зохистой ашиглах бол хамтын менежментийн нөхөрлөл нь хамтын менежментээр хариуцаж байгаа нутаг дэвсгэрийнхээ тодорхой төрлийн байгалийн нөөцийг хуулийн	

			хүрээнд гэрээнд заасны дагуу зохистой ашиглах зохицуулалттай. Нөгөөтэйгүүр, малчин өрхийн анхдагч холбоо болон байгалийн менежментийн нөхөрлөл нь ямар түвшинд хоорондоо харилцах, эдгээрийн хооронд гарсан аливаа асуудлыг сум, аймгийн түвшинд хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой тусгах нь зүйтэй байна.	
	7.1.3.төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;	Малчны тухай хуулийн 4.2.7, 4.2.8-д, Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн 27.1-т гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед төрөөс авах арга хэмжээг тус тус заасан. Малчны тухай хуульд заасны дагуу гамшигт болон аюулт үзэгдлийн улмаас хохирсон малчинд төрөөс тусламж үзүүлэх бол Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар анхдагч холбоонд төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан ба анхдагч холбоонд үзүүлэх дэмжлэгийн хэмжээ, төрлийг нарийвчлан заагаагүй байна.		-
Зөрчил	7.2.1.тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Малчны тухай хуулийн 3.1.2."мал аж ахуй" гэж уур амьсгалын нөхцөлд дасан зохицсон, байгалийн нөөц, чадавхад нийцсэн, уламжлалт болон шинжлэх ухааны арга барилд суурилсан био үйлдвэрлэлийг; 3.1.6."хот айл" гэж хоёр ба түүнээс дээш малчин өрх хамтран хөдөлмөрөө хоршин мал аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрийг; гэсэн тодорхойлолт нь	Хуулийн зорилт (1.2 дахь хэсэг) үзэл баримтлалаас үзэхэд малчин өрхийн хамтын менежментийн суурь нэгж нь Малчин өрхийн анхдагч холбоо юм. Харин хуулийн нэрийг эдгээр холбооны нэгдсэн холбооны тухай хууль байдлаар нэрлэсэн нь хуулийн зорилгоос зөрүүтэй байна. Хуулиар анхдагч холбоо болон нэгдсэн холбооны эрх зүйн байдлыг тогтоосон хэдий ч дээр дурдсанчлан малчдын хоршлыг дэмжих нь гол харилцаа тул хуулийн нэрийг ерөнхийлөн Малчин өрхийн холбооны тухай хууль гэж нэрлэх нь үзэл баримтлалтайгаа нийцтэй байна.	-
		Газрын тухай хуулийн 52.7-д “Өвөлжөө, хаваржааны доорхи газрыг Монгол Улсын иргэн хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно.” гэж заасан. Малчны тухай хуулийн 10.4.6-д зааснаар малчин,	-	-

		хот айл, малчдын холбооны санал, санаачилгаар цас борооны ус тогтоох, усан сан, нуур, хөв, цөөрөм байгуулах, сэргээгдэх эрчим хүч ашиглах тохиолдолд эдгээр байгууламжийг хот айл дундын эзэмшлийн буюу өвөлжөө, хаваржааныхаа газар болон ойролцоо байгуулах шаардлагатай тул 7.3-т заасан хориглох заалтыг боловсронгуй болгож хязгаарыг тодорхойлох шаардлагатай.		
	7.2.3.хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;	Малчны тухай хуулийн 7.3, 7.4 дэх хэсэг 7 дугаар зүйл болох Малчны хөгжлийг дэмжих төсөл хөтөлбөр гэсэнтэй агуулга нийцэхгүй байна. Мөн 7.3 дахь хэсэгт зөвшөөрөл олгохыг хэнд хориглож байгаа нь тодорхойгүй.	-	-
		10 дугаар зүйл.Малчны хамтын санаачилга, хоршил, кластерын үйл ажиллагаа гэсний “Кластер” буюу кластерийн үйл ажиллагаа (cluster) гэдэг нь гэж газар зүйн байршлын хувьд болон нэмүү өртөг бий болгох боломжтой зорилго, үйл ажиллагаагаар хорших, төрөлжих хэлбэрээр нэгдсэн зохион байгуулалтад орж хамтран ажиллахыг ойлгоно. Малчны тухай хуульд “кластер” гэсэн үгийг ашиглахдаа шууд галиглан ашигласан байх бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тодорхой тохиолдолд энэ нь зөвшөөрөгдөнө. Харин энэ хуульд “кластер”-г өөр байдлаар дахин ашиглаагүй байх хасах буюу монгол үгээр орчуулан илэрхийлэх нь зүйтэй байна.	-	51 дүгээр зүйл.Татан буулгах комиссыг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэх 51.1.Татан буулгах комиссын гишүүдийг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, холбогдох баримт бичгийг хүргүүлнэ. Зүйлийн гарчигт татан буулгах комиссыг улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэхээр байгаа боловч зүйлийн заалт нь татан буулгах комиссын гишүүдийг хүргүүлэхээр заажээ.

	7.2.4.хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгагүй, ойлгомжтой байгаа эсэх;	Малчны тухай хуулиар малчны хамтын санаачилга, хоршил нь 1. Хот айл, 2. Малчдын холбоо, 3. малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани байхаар заасан боловч Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар тодорхойлсон “малчин өрхийн холбоо”-г уг төрөлд оруулаагүй байна. Малчны тухай хуульд заасан малчдын холбоо нь Иргэний хуулийн дагуу “бүртгэгдээгүй холбоо” хэлбэртэй байх ба Малчин өрхийн холбоо нь уг хуулиар малчдын санаачилга, хоршилд хамаарахгүй байдлаар тусгажээ.		Хуулийн 25.4-т зааснаар Болзошгүй эрсдэлээс хамгаалах санд заавал байлгах хөрөнгийн хэмжээ нь хоршооны сүүлийн гурван жилийн борлуулалтын орлогын дунджийн 20 хувиас хэтрэхгүй байна гэж заавал байлгах хөрөнгийн хэмжээний хамгийн дээд хязгаарыг хуульчлан тогтоосон нь алдаатай гэж үзэж байна. Заавал байлгах нөөц нь аливаа хуулийн этгээдийн үйл ажиллагааны эрсдэлийг багасгах, харилцагчдын болон зээлдүүлэгчдийн хөрөнгө, эрх ашгийг хамгаалах зорилготой тул доод хэмжээг хуулиар босго тавьж, харин дээд хэмжээг хоршоо өөрөө дүрмээрээ зохицуулдаг байхаар өөрчлөх нь зүйтэй.
	7.2.5.хуульд тодорхойлсон нэр томьёог бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байгаа эсэх;	-	-	Хуулийн 10.3.14, 23.1-т тус тус хувь хөрөнгө гэж дурдсан байна. “Хувь хөрөнгө” гэсэн хөрөнгийн талаар Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд байхгүй. Харин Нөхөрлөлийн тухай хуульд “хувь хөрөнгө” гэж байгаа. Хоршооны гишүүний оруулсан хөрөнгө, нийлүүлсэн хөрөнгө зэргээр өөрчлөлт оруулах боломжтой.

	7.2.13.Тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх	-	Хуулийн 4.1.4-т заасан "байгалийн нөөц" гэсэн тодорхойлолт нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуультай зөрчилдөж байна. Байгалийн нөөц буюу Natural resource гэдэг нь хүний гараар бүтээгдээгүй, байгальд байдаг ус, хөрс, ургамал, амьтан зэрэг хүний хэрэгцээнд ашиглах эх үүсвэр болдог зүйлийг өргөн утгаар хэлдэг. Гэвч Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуульд байгалийн нөөцийг гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн ургамал, уст цэг, ан амьтан зэргийг гэж хумьж тодорхойлсон байна. Мөн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар төлбөр ногдох зүйлд ургамал, ус, рашааны нөөц, ойн нөөц, ан амьтны нөөц зэргээр өргөн хүрээгээр заажээ. Иймд “байгалийн нөөц” гэдгийг зөвхөн Малчны тухай хуульд заасан харилцааны хүрээнд тусгайлан тодорхойлох боломжтой юм.	-
Хийдэл	7.3.1.тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;	Энэ хуулийн 10.1.3-т малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани гэж заасан бөгөөд Нөхөрлөлийн тухай хууль (1995), Хоршооны тухай хууль (2021), Компанийн тухай хууль (2011) тус тус батлагдсан. Үүнээс гадна хамтын хоршилд хамаарах нэг хэлбэр нь Малчин өрхийн холбоо бөгөөд энэ нь Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулагдана.		-
			Хуулийн 9.2-т энэ хуулийн 9.1.1, 9.1.2-т заасан харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна гэж заасан хэдий ч ямар хуулиар зохицуулах нь тодорхойгүй. Мөн Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд “7.4.Иргэн өөрийн болон гэр бүлийн гишүүний эрүүл мэндтэй холбоотой асуудлаар	

			өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчид хандах бөгөөд эмчийн заавар, чиглэлээр эрүүл мэндийн холбогдох бусад байгууллагад хандана.” гэж заасны дагуу малчид, иргэд өөрсдөө холбогдох эмнэлгийн байгууллагадаа хандах эрхтэй. Малчин өрхийн холбоо энэхүү харилцаанд ямар үндэслэлээр холбооны гишүүний өмнөөс мэргэжлийн болон эрүүл мэндийн бусад тусламж, үйлчилгээ авах хүсэлтийг сумын эрүүл мэндийн төвд уламжилж байгаа болон хэрхэн хамтран ажиллах нь тодорхойгүй.	
	7.3.2.тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;	Уг хуулийн 4.3. дахь хэсэгт заасан Энэ хуулийн 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7, 4.2.8, 4.2.9-д заасан, Засгийн газраас батлах журмууд тайлан боловсруулах үед батлагдаагүй байна. Мөн 6.2-т заасан сургалтын хөтөлбөр, 7.2, 7.8-д заасан журмууд батлагдсан мэдээлэл байхгүй.	Газрын тухай хуулийн 52.12-т Малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах журам, гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална гэж заасан боловч батлагдаагүй байна. Тайлан боловсруулах хугацааны байдлаар уг журам болон гэрээний загварын төслийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болон Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо ТББ хамтран боловсруулахаар санамж бичиг байгуулсан байна.	-

	7.3.3.тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;	Хуулийн 7.2-т аймаг, сумын Засаг дарга орон нутгийн онцлогт нийцүүлж, малчны хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг байгаа бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг Малын тоо толгойн татвараас төвлөрөх эх үүсвэрээс бүрдүүлэх агуулгатай заалт боловч тодорхой ямар журмаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх тодорхой бус.	Хуулийн 15.6-д Гишүүнчлэлээс гаргасантай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх журмыг дүрэмд зааж болно гэж заасан ба Бүх гишүүдийн хурлаас гишүүнчлэлээс гаргасан бол тухайн шийдвэрт гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх зохицуулалтын талаар дүрэмд заахыг хуульчлах нь зүйтэй. Учир нь гишүүний төлсөн хураамж, дундын өмчлөлийн гэх мэт эрхийн болон өмчлөлийн асуудал үүсэх боломжтой бөгөөд эрх зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх талаар хуульд тодорхой зохицуулалт хийж шийдвэрлэх нь нийцтэй байна.	-
			Хуулийн 24.1.6-д мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх чухал үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан боловч үүнтэй холбоотой нарийвчилсан харилцааг тусгаагүй.	
			Хуулийн 26.2-т Аймгийн болон сумын холбоо нь орон нутгийн зохих шатны удирдлагад холбооны үйл ажиллагааны тайланг танилцуулна гэж заасан. Уг Үйл ажиллагааны тайланг танилцуулах хугацааг аймаг, сумаар ялгаатай, тодорхой тогтоосноор үйл ажиллагаа нээлттэй, хариуцлагатай бөгөөд энэ заалт хэрэгжих гол нөхцөл болно.	
			Хууль тогтоомжийн тухай хуулиар хуулийн төсөлд шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах шаардлагыг тавьдаг. Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар бэлчээр, байгалийн нөөцийг	

			зохистой ашиглах, сэргээх, гэрээний үүргээ сахин биелүүлэх зэрэг үүргээс гадна холбооны үйл ажиллагаа, түүний тайланд тавигдах шаардлага зэрэг зохицуулалтыг тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг оруулаагүй нь энэхүү хууль нь эрх зүйн талаасаа чадваргүй, зөвхөн тунхгийн шинжтэй баримт бичиг болох эрсдэлтэй юм.	
	7.3.4.тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх;	Малчны тухай хуулиар малчин нь байгалийн нөөц, бэлчээрийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу гэрээгээр ашиглах эрхээ баталгаажуулах эрхтэй бөгөөд бэлчээрийг даацад нь нийцүүлэн улирлын хуваарьтай ашиглаж, сэлгэх, өнжөөх, сайжруулах, нөхөн сэргээх зэргээр бэлчээрийн төлөв байдал, голлох зүйл ургамлын эзлэх хувийг гэрээ байгуулах үеийн тогтоосон суурь түвшнээс бууруулахгүй байх үүрэгтэй байхаар заасан. Мөн тус хуулиар малчны хамтын санаачилга, хоршил нь хот айл, малчны холбоо, малчдын үүсгэн байгуулсан нөхөрлөл, хоршоо, компани хэлбэртэй байхаар заасан боловч малчин, малчны хамтын санаачилга, хоршилд бэлчээр гэрээгээр ашиглуулахтай холбоотой зохицуулалт Малчны тухай хууль болон дагалдан гарсан хуулиудад тусаагүй байна. Мөн Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулиар малчин өрхийн анхдагч холбоонд бэлчээрийг гэрээгээр ашиглуулах, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээр дэх байгалийн нөөцийг хууль тогтоомжид заасны дагуу ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой зохицуулалтуудыг тусгаж, мөн тус хуулийн дагалдан Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтуудыг тусгажээ. Одоогийн хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд малчин өрхийн холбоонд хамаарахгүй малчин болон Малчны тухай хуульд заасан малчны хамтын санаачилга, хоршил нь гэрээгээр бэлчээр ашиглахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс шалтгаалан малчин малчин өрхийн холбоонд нэгдэх замаар бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахаас аргагүй байдалд хүрэх, улмаар сайн дурын үндсэн дээр малчин өрхийн холбоонд элсэх суурь зарчим гажуудах эрсдэлтэй байна.	-
		Хуулийн 8 дугаар зүйлд Малчны үйл ажиллагаанд цахим шилжилтийг нэвтрүүлэх талаар дараах зүйлсийг	-	-

		тусгасан бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх субьект тодорхойгүй. Үүнд: 8.1.1.хөдөлгөөнт холбоо, телевиз, интернэт сүлжээний үйлчилгээ; 8.1.2.мэдээлэл авах, солилцох нэг цонхны цахим үйлчилгээ; 8.1.3.банк, санхүү, татвар, худалдааны цахим үйлчилгээ; 8.1.4.төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээний цахим систем; 8.1.5.малын бүртгэлийн систем; 8.1.6.гойд ашиг шимт, шилмэл малын үзэсгэлэн, дуудлага худалдаа, захиалга, малын тэжээл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн цахим худалдаа; 8.1.8.технологийн сүлжээгээр дамжуулан малчдад мэдлэг түгээх бусад цахим үйлчилгээ зэрэг болно.		
	7.3.5.төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;	Хуулийн 16.1-т “Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө” гэж заасан. ЗГ-аас холбогдох журмыг уг заалтын хүчинтэй хугацаанд бүрэн хэрэгжиж дуусах боломжтой хугацаанд батлах шаардлагатай бөгөөд энэхүү тайланг боловсруулах үед уг журмыг батлаж гаргаагүй байна. Журмын төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын цахим хуудсанд байршуулсан байна.	-	Хуулийн 42.1.4 дэх заалтаар хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хоршооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх бүрэн эрхтэйгээр заасан боловч Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн хоршооны мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх тусгайлан эрх олгосон заалт оруулаагүй. Хоршооны мэдээллийн цахим санг хэрхэн бүрдүүлэх, хадгалах, дамжуулах, мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хамгаалах зэрэг асуудлыг тусгасан захиргааны хэм хэмжээний акт батлагдсанаар хуулийн энэхүү заалтаар олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх нөхцөл үүснэ
	7.3.6.хуульд заасан хориглосон зохицуулалт	Хуулийн 15.1-т энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт	-	Зөрчлийн тухай хуулийн 10.10 дугаар зүйл.Хоршооны тухай хууль зөрчих

	нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;	хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж, 15.2-т энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэж тус тус заасан боловч Зөрчлийн тухай хуулийн 13.11 дүгээр зүйлд заасан Малчны тухай хуулиар тогтоосон журам зөрчих гэсэн зөрчил нь зөрчлийн шинж, чанар зэргээр тодорхойлогдоогүй, ямар нөхцөл байдал үүссэнийг зөрчилд тооцох нь тодорхойгүй байна.		гэсэн зүйлд 1.Хоршооны тухай хууль зөрчиж дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгүүлэх журам зөрчсөн, эсхүл дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж заасан. Гэтэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу энэ зөрчилд Улсын бүртгэлийн хяналтын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зохицуулалттай. Өөрөөр хэлбэл Хоршооны тухай хуульд заасан өөр зохицуулалтыг зөрчсөнөөс үүсэхтэй холбоотой асуудлыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээргүй байна. Түүнчлэн, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан хэдий ч Хоршооны үүргийг биелүүлээгүй этгээдэд авах арга хэмжээ Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль аль альд тусгагдаагүй. Хяналтын процедур тодорхойгүй байна.

---000---

Хавсралт 2

МАЛЧНЫ ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийн нэр	Малчны тухай хуулийн холбогдох зохицуулалт
Иргэний хууль	**481 дүгээр зүйл. Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл** 481.1.Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хэд хэдэн этгээд холбоо болон нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдаж үйл ажиллагаа явуулж болох бөгөөд ийм байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэхгүй, бүтэц, зохион байгуулалтыг гишүүд харилцан тохиролцож тодорхойлно. 481.2.Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл нь иргэний эрх зүйн харилцаанд бүрэн эрх бүхий төлөөлөгч буюу гишүүдээр дамжин оролцоно. **482 дугаар зүйл. Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн гишүүдийн дундын хөрөнгө** 482.1.Холбооны гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагааныхаа орлогоор олж авсан хөрөнгө нь гишүүдийн дундын хөрөнгө байна. 482.2.Дундын хөрөнгөд оруулах татвар, хуримтлалын хэмжээг гишүүд тохиролцон тогтоох бөгөөд тэдгээр нь мөнгө, эд хөрөнгө болон үйл ажиллагаагаараа дундын хөрөнгийг бүрдүүлэхэд оролцож болно. 482.3.Дундын хөрөнгийг гишүүдээс томилогдсон эрх бүхий төлөөлөгч захиран зарцуулна. 482.4.Нэхэмжлэгчдийн шаардлагыг гишүүдийн дундын хөрөнгөөр хангана. Орон сууцны дундын өмчлөлийн зүйл энэ заалтад хамаарахгүй. 482.5.Гишүүд өөрөөр тохиролцоогүй бол дундын хөрөнгө шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд холбоо, нөхөрлөлийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бүрэн эрх бүхий этгээдүүд ижил хэмжээгээр нөхөх хариуцлага хүлээнэ.
Малын генетик нөөцийн тухай хууль	8.7.Малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэж, гэрчилгээ, баталгааны тэмдэг олгоно.

	8.8.Энэ хуулийн 8.7-д заасан гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох, хэрэглэх болон малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх журмыг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль	4.1.14."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасан иргэнийг; 4.1.15."амьтан маллагч" гэж амьтныг арчлах, тэжээх, болзошгүй аюулаас хамгаалах, хашаа, байр, нөмөр, хорго, хэвтрийг цэвэрлэх үүрэгтэй иргэнийг; 7.1.Малчин, амьтан маллагч нь мал, амьтан маллах, ашиглах, эдлэх, тээвэрлэхдээ мал, амьтны тавлаг байдлыг хангаж, хашаа, байр, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн эрүүл ахуй, ариун цэврийн нийтлэг зааврыг дагаж мөрдөнө. 7.2.Энэ хуулийн 7.1-д заасан зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална. 7.3.Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд доор дурдсан этгээд дараахь үүргийг хүлээнэ: 7.3.1.мал, амьтан өмчлөгч малын эмчийн зааварчилгааны дагуу өвөлжөө, хаваржаа болон эрчимжсэн мал аж ахуйн байрны ойр орчимд мал, амьтны хүүр, сэг зэм, биологийн хаягдал устгах зориулалтын цэг барьж ашиглах; 7.3.2.малчин, амьтан маллагч нь хашаа, байрны ойр орчимд болон ашиглаж байгаа бэлчээрт энэ хуулийн 7.3.3-т зааснаас бусад шалтгаанаар үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах; 7.3.3.сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулж устгах, бэлчээр, уст цэг, үерийн жалга, усны эх булгийг цэвэрлэх арга хэмжээг зохион байгуулах; 7.3.4.гудамж, талбай, цэцэрлэг болон нийтийн эзэмшлийн газар үхсэн мал, амьтны талаархи иргэн, байгууллагаас мэдээлэл хүлээн авсан харьяалах хорооны Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгж /цаашид "гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж" гэх/-тэй хамтран

	цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, шаардлагатай үед сорьц авч лабораторид хүргүүлэх; 7.3.5.хот, суурин газрын нутаг дэвсгэрт мал, амьтан маллаж байгаа иргэн, хуулийн этгээд Эрүүл ахуйн тухай хуулийн 20.1.8-д заасан үүрэг хүлээх; 7.3.6.мал, амьтан үхсэн бол хашаа, байр, орчныг халдваргүйтгэх ажлыг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж гүйцэтгэх. 9.4.Дархлаажуулалтын товыг мал эмнэлгийн тасаг тогтоож, баг, хорооны Засаг дарга малчин, амьтан маллагчид зарлан мэдээлнэ. 9.8.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч дархлаажуулалт хийх үед дараахь үүрэг хүлээнэ: 9.8.1.товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж, бүрэн хамруулах; 9.8.2.мал, амьтныг барьж бэхлэн, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, малын эмчийн аюулгүй байдлыг хангах. 14.4.Малчин, амьтан маллагч мал, амьтнаас сорьц авах үед энэ хуулийн 9.8-д заасан үүрэг хүлээнэ. 15.2.Энэ хуулийн 15.1-д заасан нөхцөл үүссэн үед малчин, амьтан маллагч дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ: 15.2.1.шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, ойролцоо малчдад мэдэгдэх; 15.2.2.энэ хуулийн 9.8.2-т заасан үүрэг хүлээх; 15.2.3.өвчний сэжигтэй мал, амьтныг сүргээс тусгаарлахад зориулан хашаа, байр бэлтгэх, тусгаарлан маллах, арчлах; 15.2.4.малын эмчийн заавар, зөвлөмжийг биелүүлэх. 21.3.Энэ хуулийн 21.2-т заасан төлөвлөгөөг хэрэгжүүлэх үед малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч доор дурдсан үүрэг хүлээнэ:

	21.3.1.энэ хуулийн 21.2-т заасан төлөвлөгөөнд тусгагдсан шимэгчтэх өвчинд мэдрэмтгий мал, амьтныг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс тогтоосон хугацаанд бэлэн байлгаж, бүрэн хамруулах; 21.3.2.энэ хуулийн 9.8.2-т заасан үүргийг биелүүлэх. 22.3.Малчин, амьтан маллагч нь мал, амьтныг өдөр тутам ажиглах, өвчилсөн, гэмтсэн үед анхны тусламж үзүүлж, сонгосон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид мэдэгдэнэ. 22.4.Энэ хуулийн 22.3-т заасан мал эмнэлгийн үйлчилгээний нэгж халдваргүй өвчний оношийг эмнэл зүйн шинж тэмдэг, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн тогтоож, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчийн зөвшөөрснөөр эмчилгээ хийнэ. 22.5.Гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь мал, амьтны халдваргүй өвчин, тэдгээрийн эрсдэл, хор уршиг, сэргийлэх арга хэмжээний талаар харьяалах нутаг дэвсгэрийн малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчид улирал тутам зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд мал эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. 30.10.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч тухайн нутаг дэвсгэрт байнга болон түр хугацаагаар үйлчилгээ үзүүлж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг өөрөө сонгон үйлчлүүлэх эрхтэй.
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль	3.1.9."малчин" гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг; 6.3.3.малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийг дэмжих, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих; 12 дугаар зүйл.Малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих 12.1.Малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих арга хэмжээ нь иргэний ганцаараа болон бусадтай хамтран аж ахуй

	эрхлэх санаачилгыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах, жижиг зээл, санхүүгийн дэмжлэг, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг арга хэрэгслээр дэмжин туслах хэлбэртэй байна. 12.2.Малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих зориулалттай жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох бөгөөд уг сангаас олгох жижиг зээлийг банкаар дамжуулан олгоно. 23.1.7.малчин, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;
Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль	9 дүгээр зүйл.Малчны эрх, үүрэг 9.1.Малчин дараах эрх, үүрэгтэй: 9.1.1.мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхлэх хүрээнд хоршоо байгуулах, зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дэмжсэн малчдын хоршоонд элсэх; 9.1.2.малын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлээ өргөтгөх, үр ашгийг нэмэгдүүлэх; 9.1.3.өөрийн мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилыг тогтмол сайжруулах, сургалтад хамрагдах, мэдээлэл, зөвлөгөө авах; 9.1.4.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах; 9.1.5.өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах; 9.1.6.хуулиар хүлээсэн бусад эрх, үүрэг.
Малын тоо толгойн албан татварын тухай хууль	3.1.2. ."малчин" гэж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.9-д заасныг; 4.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна.

Тариалангийн тухай хууль	17.5.Тариалангийн бүс нутагт суурин болон хагас суурин эрчимжсэн мал аж ахуйг тусгайлсан бэлчээрт эрхэлнэ. 24.1.1.мал, тэжээвэр амьтан оруулах, бэлчээх; 24.2.Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа байхыг хориглоно.
Зөрчлийн тухай хууль	**13.4 дүгээр зүйл.Малын генетик нөөцийн тухай хууль зөрчих** 2.Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь: 2.1.цөм сүргийн болон үржлийн малыг технологит хугацаанд үзлэг ангилалтад хамруулаагүй, ашиг шимт чанарыг үнэлүүлж, баталгаажуулаагүй; 2.2.үр, хөврөлийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн хяналтын доор ашиглаагүй бол зөрчлийг арилгуулж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **13.9 дүгээр зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль зөрчих** 1.Нийтийн хэрэгцээнд зориулан мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд мал төхөөрсөн бол зөрчлийг арилгуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Мал эмнэлгийн холбогдолтой журам, заавар зөрчсөний улмаас өвчин тархаах, малын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдах, мал, амьтныг тарчлаан зовоох нөхцөл байдал үүссэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 3.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь дархлаажуулалт хийх, сорьц авах үед болон мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, тодорхой бус шалтгаанаар хорогдсон тохиолдолд авч хэрэгжүүлэхээр хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх

	хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 4.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм хэрэглэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 9.Малчин, амьтан маллагч нь: 9.1.өөр сум, дүүргийн нутаг дэвсгэрээс мал, амьтан шилжүүлэн авчирсан даруй үзлэг хийлгэн тухайн сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасагт бүртгүүлээгүй, хяналтын цэгт шалгуулахгүй өнгөрсөн, эсхүл тогтоосон замаас өөр замаар тээвэрлэсэн, тууварласан; 9.2.эрүүл мэндийн тодорхойлолт авалгүйгээр бусад сум, дүүргийн нутаг дэвсгэрт мал оторлосон; 9.3.хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон бүс хооронд мал, амьтан тууварласан, тээвэрлэсэн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 10.Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт: 10.1.орон нутгийн онцгой комиссын зөвшөөрөлгүйгээр бэлчээр, нутаг сэлгэсэн; 10.2.нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан, хүн, мал, амьтны бөөгнөрөл бий болгосон; 10.3.мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан; 10.4.халдварт өвчнөөр өвчилсөн мал, амьтан байрлаж байсан хашаа, байр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг халдваргүйтгэхээс өмнө дахин ашигласан бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

	13.11 дүгээр зүйл.Малчны тухай хууль зөрчих 1.Малчны тухай хуулиар тогтоосон журмыг зөрчсөн хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хавсралт 3

МАЛЧНЫ ӨРХИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийн нэр	**Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зохицуулалт**
Газрын тухай хууль	3.1.11.“малчин өрх” гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.2-т заасныг; 3.1.12.“малчин өрхийн анхдагч холбоо” гэж Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.3-т заасныг; 3.1.13.“бэлчээрийн даац” гэж тухайн бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр бэлчээж болох мал, амьтны тоогоор илэрхийлэгдэх бэлчээрийн чадавхыг. 19.3.1.бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 19.3.2.бэлчээрийн даац тогтоох аргачлалыг байгаль орчны асуудал эр 20.1.6.тухайн орон нутгийн онцлогт тохируулж, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх журмыг батлах; 20.1.7.аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын тухайн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг үндэслэн малчин өрхийн анхдагч холбоонд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн зааг, хэмжээ, байршлыг тогтоох.хэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах. 20.2.10.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас отрын бэлчээр, бусад аймаг, сумын бэлчээрт түр хугацаагаар мал оруулах, гаргах асуудлыг холбогдох аймаг, сумын Засаг даргатай хамтран шийдвэрлэх;

	20.2.11.энэ хуулийн 20.2.10-т заасны дагуу шийдвэрлээгүй бол уг асуудлыг дээд шатны Засаг дарга, Засгийн газар шийдвэрлэх. 21.4.4.бэлчээрийг малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах гэрээ байгуулах; 21.4.5.гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийг гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон үед тухайн сумын малчдад бэлчээрийн даацад тохируулан түр хугацаагаар ашиглуулах асуудлыг шийдвэрлэх; 21.4.6.гамшиг, аюулт үзэгдлийн улмаас бусад аймаг, сумын малыг отрын бэлчээр болон бусад бэлчээрт түр хугацаагаар оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх; 21.4.7.өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун, намрын улиралд малаас чөлөөлөх хугацааг тогтоож, мөрдүүлэх. 23.4.7.бэлчээрийн даацыг хөдөө, аж ахуйн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан аргачлалын дагуу сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран жил бүр тогтоох; 23.4.8.малчин өрхийн анхдагч холбоонд ашиглуулах бэлчээрийн зааг, хэмжээ, байршлын зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэх; 23.4.9.энэ хуулийн 21.4.4-т заасан гэрээг бүртгэх, гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн ашиглалт, төлөв байдлын үнэлгээг үндэслэн сумын бэлчээр хариуцсан мэргэжилтэнтэй хамтран уг гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавих, дүгнэх.
Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль	22.1.22.бэлчээрийн ашиглалт, хамгаалалт.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	16.2.11/хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгаль орчин болон байгалийн нөөцөд учруулсан хохирлыг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгийг тухайн төсөл, арга хэмжээний төсөвт тусгуулах.

	18.1.2/нийтийн ашиглалтын байгалийн баялгийн хамгаалалт, ашиглалтад хяналт тавих; 18.2.2/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж, малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах, орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах; 18.2.6/бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн болон тариалангийн талбай, бэлчээр, уст цэгийг хамгаалах, ашиглах хуваарь гаргаж зохицуулах. 32.2.Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан малчин өрхийн холбоо зэрэг этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.
Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай	3.2.Малчинд төрөөс дэмжлэг үзүүлэх арга хэмжээг энэ хууль, холбогдох бусад хуулиар зохицуулна. 3.3.Малчин хоршоо байгуулах, хоршоонд элсэх үйл ажиллагааг Хоршооны тухай хуулиар зохицуулна. 6.1.3.малчид нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дурын үндсэн дээр хамтрах, хоршоо байгуулах, малчдын хоршоонд элсэх санаачилгыг дэмжих; 6.1.6.малчид харилцан суралцах, мэдлэг, туршлагаа хуваалцах, малчны залгамж халааг бэлтгэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх; 9.1.Малчин дараах эрх, үүрэгтэй: 9.1.1.мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхлэх хүрээнд хоршоо байгуулах, зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дэмжсэн малчдын хоршоонд элсэх; 9.1.2.малын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлээ өргөтгөх, үр ашгийг нэмэгдүүлэх; 9.1.3.өөрийн мэдлэг, туршлага, ур чадвар, арга барилыг тогтмол сайжруулах, сургалтад хамрагдах, мэдээлэл, зөвлөгөө авах;

	9.1.4.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах; 9.1.5.өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг малын тоо толгойтой уялдуулан хангах, өвөлжөө, хаваржааны малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал тариалах; 9.1.6.хуулиар хүлээсэн бусад эрх, үүрэг.

Хавсралт 4

ХОРШООНЫ ТУХАЙ ХУУЛЬТАЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хуулийн нэр	Хоршооны тухай хуулийн холбогдох зохицуулалт
Иргэний хууль	16.4. 16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн байж болно. 33.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг холбоо, сан, хоршооны хэлбэрээр байгуулна. 36.4.Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дурааараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ. 36.5.Хоршоог үүсгэн байгуулах, бүртгэх, хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох, хоршооны гишүүнчлэл, хяналт болон хоршоотой холбоотой бусад харилцааг хуулиар зохицуулна.
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	4.1.1."аж ахуйн нэгж" гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг; 21.1.12.гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны зуучилсны үнийн зөрүүгээс олсон хоршооны орлого.
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль	7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: 7.1.5.хоршоо;
Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг	2.1.Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хоршооны тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

нөлөөллийг бууруулах тухай	3.1.Энэ хууль уламжлалт мал аж ахуйг уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, гамшгийн эрсдэлийг хохирол багатай даван туулах, малчны эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор малчдын хоршоог дэмжих харилцаанд үйлчилнэ. 3.3.Малчин хоршоо байгуулах, хоршоонд элсэх үйл ажиллагааг Хоршоо6.1.3.малчид нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор сайн дурын үндсэн дээр хамтрах, хоршоо байгуулах, малчдын хоршоонд элсэх санаачилгыг дэмжих; 6.1.4.мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх хүрээнд малчдын хоршооны хөрөнгө оруулалтад шаардагдах эх үүсвэрт дэмжлэг үзүүлэх;ны тухай хуулиар зохицуулна. 7.1.1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүс тус бүрийн онцлогт тохирсон малчдын хоршооны загварыг боловсруулах; 7.1.2.малчдын анхан шатны болон дундын хоршооны үйл ажиллагааны чиглэлд тохирсон дэмжлэгийг бий болгох, хоршоог чадавхжуулах арга хэмжээг авах; 7.1.4.уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадвартай бүс нутгийн онцлогт тохирсон, баталгаажсан үүлдэр, омгийн малаар сүргийг сайжруулахад малчдын хоршоонд дэмжлэг үзүүлэх; 9.1.Малчин дараах эрх, үүрэгтэй: 9.1.1.мал аж ахуйн тогтвортой үйлдвэрлэл эрхлэх хүрээнд хоршоо байгуулах, зорилго, үйл ажиллагааны чиглэлийг дэмжсэн малчдын хоршоонд элсэх; **10 дугаар зүйл.Малчдын хоршооны үүрэг** 10.1.Малчдын хоршоо дараах үүрэгтэй: 10.1.1.банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн үүргээ биелүүлэх; 10.1.2.олон улсын байгууллагын санхүүжилтээр олгосон хөнгөлөлттэй зээлийн зарцуулалт тухайн орон нутгийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан нэгжээр дамжуулан

	хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах; 10.1.3.байгальд ээлтэй үйлдвэрлэлийг тогтвортой эрхлэх, хариуцлагатай байх; 10.1.4.эрх бүхий байгууллагаас гаргасан журам, заавар, стандартын шаардлагыг мөрдөх; 10.1.5.өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах; 10.1.6.малын гаралтай түүхий эдийн анхан шатны ангилалт, тордолт хийж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх, стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх; 10.1.7.малын тоо толгойг бэлчээрийн даацад тохируулан зохистой хэмжээнд байлгах, даацаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаарх төлөвлөгөөг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталж, үе шаттай хэрэгжүүлэх; 10.1.8.хуулиар хүлээсэн бусад үүрэг.

___o0o___

Хавсралт 5

БАТЛАВ. ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
САЙД Ц.НЯМДОРЖ

Хуулийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал

Нэг. Зорилго

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь иргэн, эдийн засгийн хууль тогтоомжид байгаа давхардал, зөрчил, хийдлийг тогтоох замаар тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, иргэн, хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Ерөнхий ойлголт

2.1. Энэхүү аргачлал дахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах-хууль тогтоомжийг харьцуулан судлах замаар тэдгээрийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоон арилгах цогц үйл ажиллагааг;

2.1.2. давхардал-хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэл зүйн хувьд хуулбарласан, эсхүл тэдгээрийн зохицуулалтын агуулга, зорилго нь ижил байхыг;

2.1.3. зөрчил-ижил субьектуудын зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, Үндсэн хууль болон органик хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томъёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг;

2.1.4. хийдэл-тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг.

Гурав. Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх үндсэн арга

3.1. Хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах /цаашид “уялдаа холбоог сайжруулах” гэх/ ажлыг зохион байгуулахдаа дараахь үндсэн аргыг хэрэглэнэ:

3.1.1. анализ-синтезийн арга;

3.1.2. ярилцлагын арга;

3.1.3. харьцуулалтын арга:

а/бичвэрийн харьцуулалтын арга;

б/агуулгын харьцуулалтын арга.

3.1.4. хууль тогтоомжийн эрэмбэлэлийн арга

3.2. Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийхдээ хууль тогтоомжийн бичвэр болон агуулгыг харьцуулах бөгөөд хууль тогтоомж давхардсан, зөрчилдсөн гэж үзвэл түүнийг хууль тогтоомжийн эрэмбэлэлийн аргын дагуу хамгийн дээд хүчин

чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд бусад хууль, эрх зүйн актыг нийцүүлэх замаар ажиллана.

Дөрөв. Уялдаа холбоог сайжруулах ажлыг хийх үе шат

4.1. Уялдаа холбоог сайжруулах ажлыг дараахь үе шатаар хийнэ:

4.1.1. бэлтгэл үе шат;
4.1.2. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шат;
4.1.3. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системчлэх;
4.1.4. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тайлагнах;
4.1.5. хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах /хуулийн төсөл/;

Тав.Бэлтгэл үе шат нь дараахь хэсгээс бүрдэнэ.

5.1. Бэлтгэл үе шатанд сонгож авсан хуультай холбоотой дараахь эрх зүйн актыг цуглуулна:

1/ Хууль;
2/ ОУ-ын гэрээ;
3/ УИХ-ын тогтоол;
4/Ерөнхийлөгчийн зарлиг;
5/Үндсэн хуулийн Цэцийн шийдвэр;
6/Улсын Дээд шүүхийн тогтоол;
7/Засгийн газрын тогтоол;
8/ Сайдын тушаал;
9/ Засгийн газрын агентлагийн даргын тушаал;
10/УИХ-аас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр.

5.2. Цуглуулсан хууль, хуульчилсан актаасаа хүчинтэй үйлчилж байгааг нь ялгах: Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актын хүчин төгөлдөр эсэхийг тогтоохдоо Засгийн газрын 2003 оны 8 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга, агентлагийн даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж бүртгэх журам”-ын дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн эсэхийг удирдлага болгоно.

5.3. Цуглуулсан хууль, хуульчилсан актаа уншиж танилцаад эдгээрээс тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан актыг ялгаж авах;

Зургаа.Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шат

6.1. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох үе шатанд тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан акттай сонгож авсан хуулийн заалт бүрийг харьцуулж хүснэгтлэнэ.

6.2. Хүснэгтийн дагуу энэхүү аргачлалын 7.1-7.3-т заасан шалгуурын дагуу заалт тус бүрээр нь харьцуулан уншиж давхардал, зөрчил, хийдлийг тогтоох.

Долоо. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох

7.1. Хууль тогтоомжийн давхардлыг дараахь асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно:

7.1.1. тухайн хуульд байгаа зохицуулалтын бичвэрийг бусад хуульд давтан хуулбарлан хуульчилсан эсэх;

7.1.2. тухайн хуульд байгаа зохицуулалтыг уг хуульд болон бусад хуульд агуулгын хувьд хуулбарлан хуульчилсан эсэх;

7.1.3. төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хуульд давхардуулан хуульчилсан эсэх;

7.1.4. тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний давхардалыг арилгахад чиглэгдсэн эсэх.

7.2. Хууль тогтоомжийн зөрчлийг дараахь асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно:

7.2.1. тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

7.2.2. хууль тогтоомжийн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

7.2.3. хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэж байгаа эсэх;

7.2.4. хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд салаа утгатай эсэх;

7.2.5. хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх;

7.2.6. тодорхой асуудлыг тухайн хуулиар зохицуулахаар заасан боловч уг асуудлаар өөр журмыг өөр хуульд заасан эсэх;

7.2.7. хуульд заасан эшлэл алдаатай эсэх;

7.2.8. тухайн хуульд бусад хуулиас авсан эшлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх;

7.2.9. татварынхаас бусад хуульд тогтоомжид албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

7.2.10. тухайн хуульд тусгай зөвшөөрөл олгохоор заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд туссан эсэх;

7.2.11. өмчлөх эрхийг хязгаарласан буюу хязгаарлахад чиглэгдсэн эрх зүйн акт гаргах эрхийг бусад этгээдэд хуулиар олгосон эсэх;

7.2.12. тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний зөрчлийг арилгахад чиглэгдсэн эсэх.

7.2.13. тухайн хуулийн зүйл, заалт өөр хуулийн заалттай зөрчилдөж буй эсэх

7.3. Хууль тогтоомжийн хийдлийг дараахь асуудлыг харгалзан үзсэний үндсэн дээр тогтооно:

7.3.1. тухайн хуульд тодорхой харилцааг нарийвчлан хуулиар зохицуулахаар заасан бол уг нарийвчилсан зохицуулалт бүхий хууль батлагдсан эсэх;

7.3.2. тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бол уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэх;

7.3.3. тухайн хуульд заасан процедурын шинжтэй зохицуулалт нь ойлгомжтой, тасралтгүй үргэлжлэх боломжтой байдлаар томъёолсон эсэхийг тодорхойлох;

7.3.4. тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэх субьект нь тодорхой эсэх;

7.3.5. төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудал шийдвэрлэхээр хуульд заасан бол уг асуудлыг шийдвэрлэх хугацааг тодорхой заасан эсэх;

7.3.6. хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх;

7.3.7. тухайн хуулийн тодорхой зохицуулалтыг Улсын дээд шүүхээс тайлбарлаж байсан эсэх, энэхүү тайлбар нь түүний хийдлийг арилгахад чиглэгдсэн эсэх.

7.3.8. хуульд байх шаардлагатай зохицуулалт тусгагдсан эсэх

7.3.9. хуулийн зүйл, заалт, зохицуулалт нь ойлгомжтой байгаа эсэх;

7.4. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоох ажлын хүрээнд иргэн, хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараахь асуудлыг судалсан байна:

7.4.1. иргэдээс аливаа бичиг баримт, тайлан мэдээ авахаар заасан хуулийн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж уг баримт, тайлан мэдээ гаргуулах ач холбогдлыг талаар хуулийн хувийн хэргээс тодруулах, уг тайлан мэдээний ашиглалт, хэрэглээний талаархи мэдээллийг уг тайланг хүлээн авсан эрх бүхий байгууллагатай уулзаж мэдээлэл авах, шаардлагатай гэж үзвэл эдийн засгийн тооцооллыг хийх;

7.4.2. төрийн байгууллага, албан тушаалтнаас тодорхой асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах хуульд заасан хугацааг тогтоох, энэ хугацаа нь өргөдөл, гомдлын хуульд заасан нийтлэг журамд нийцэж байгаа эсэхийг шалгах;

7.4.3. тухайн харилцаанд оролцогч нь гадаадын хөрөнгө оруулагч гэдэг үндэслэлээр өөр журам тогтоосон эсэх, ийнхүү тогтоосон журам нь дотоодын хөрөнгө оруулагчаас дутуугүй нөхцөл олгож байгаа эсэхийг судлах.

Найм. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг системчлэх үе шат

8.1. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тогтоосны дараа тэдгээрийг системчлэнэ.

8.2. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг хууль тус бүрээр системчлэх бөгөөд хууль тогтоомжийн тодорхой зүйл, хэсэг, заалт бичвэрийн хувьд болон агуулгын хувьд давхардсан, зөрчилдсөн бол эрэмблэлийн хувьд дээд хүчин чадалтай, эсхүл суурь харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжид бусад хууль тогтоомжийг нийцүүлэх чиглэл баримтална.

Ес. Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг тайлагнах үе шат

9.1. Тайланг хууль тус бүрээр ажлын хэсгийн гишүүдийн саналыг нэгтгэн гаргана. Тайланг товч, тодорхой, албан хэргийн бичгийн найруулгындагуу бичсэн байна.

9.2.Тайлан нь дараахь хэсгээс бүрдэнэ.

а/танилцуулга;

б/дүгнэлт;

в/санал.

9.3. Танилцуулга хэсэгт дараахь асуудлыг тусгана:

-судалсан хуулийн нэр;

-судалсан хуулинд хамаарах бусад хууль тогтоомж, эрх зүйн актын тоо, төрөл;

-судалгаанд хэрэглэсэн арга;

-тухайн хууль батлагдсан нөхцөл байдал, хэрэгжилтийн талаархи товч танилцуулга.

9.4. Дүгнэлт хэсэгт дараахь асуудлыг тусгана:

-судалгааны явцад тогтоосон давхардал, ийнхүү давхардсан гэж тооцох болсон үндэслэл;

-судалгааны явцад тогтоогдсон зөрчил, ийнхүү зөрчилдсөн гэж үзэх болсон үндэслэл;

-судалгааны явцад тогтоогдсон хийдэл, ийнхүү хийдэл гэж үзэх болсон үндэслэл.

9.5. Саналын хэсэгт дараахь асуудлыг тусгана:

-судалгааны явцад тогтоогдсон давхардал, хийдэл, зөрчлийг хэрхэн арилгах боломжтой тухай санал;

-хэд хэдэн хууль хоорондоо давхардсан эсхүл, зөрчилдөж байгаа бол аль хэм хэмжээг авч үлдэх нь зохимжтой байгаа талаархи санал, түүний үндэслэл;

-тодорхой хуулийг хүчингүй болгох санал дэвшүүлсэн тохиолдолд ийнхүү хүчингүй болгохоор дэвшүүлж байгаа саналын үндэслэл /зорилгоо биелүүлсэн, нийгмийн шаардлагад нийцэхгүй байгаа, хэрэглэгдэхгүй болсон, 50 ба түүнээс дээш хувь нь бусад хуулийн зохицуулалттай давхардаж байгаа гэж мэт/.

9.6. Тайланд дараахь материалыг хавсаргана:

-тухайн хуультай холбогдох хууль тогтоомж болон эрх зүйн актын жагсаалт;

-судалгаанд ашигласан материал;

-судалгааны явцад зохион байгуулсан хурал, зөвлөгөөн, уулзалтын тэмдэглэл;

-давхардал, хийдлийг тогтоох зорилгоор боловсруулсан энэ журмын 6.1-д заасан харьцуулалттай хүснэгт;

-шаардлагатай гэж үзсэн бусад материал.

9.7. Тайланг ХЗДХЯ-нд бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

9.8. Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсэг ХЗДХЯ хамтран тайланд тодруулга болон нэмэлт хийж болно. Энэ тухайгаа тайланд заавал тусгана.

Арав.Хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах санал боловсруулах /хуулийн төсөл/ үе шат

10.1. ХЗДХЯ ажлын хэсгийн гаргасан тайлангийн саналд үндэслэн хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулна.

---oOo---